

**"ТӨРӨӨС ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО"-ЫН  
ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
(2019 оны жилийн эцсийн байдлаар)

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ**

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд 2019 онд хийсэн ажлын биелэлт, тухайн ажлыг хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж ярилцах, холбогдох статистик мэдээ, мэдээллийг ашиглан хийв.

**ХОЁР. БОДЛОГЫН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

"Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ыг УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор, эхний үе шат (2016-2020 он)-ны төлөвлөгөөг ХХАА-н сайдын 2016 оны “Төлөвлөгөө батлах тухай” А-60 дугаар тушаалаар тус тус баталсан.

**Бодлогын зорилго:** Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжил нь үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэн өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэгдэнэ.

**Бодлогын зорилт:**

**Зорилт 1.** Мал аж ахуйн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт нэмэгдүүлэх;

**Зорилт 2.** Тариалангийн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх;

**Зорилт 3.** Хүнсний аюулгүй байдал, боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;

**Зорилт 4.** Судалгаа ба хөгжлийн үйл ажиллагааг дэмжих;

**Зорилт 5.** Хөрөнгө оруулалт, худалдааг нэмэгдүүлэх;

**Зорилт 6.** Хүний нөөцийг чадавхжуулах;

**Бодлогыг хэрэгжүүлэх үе шат:**

✓ I үе шат /2016-2020 он/;

✓ II үе шат /2021-2025 он/;

**ГУРАВ. БОДЛОГЫН ТОВЧ ҮР ДҮН:**

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичигт тусгагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн үнэлгээний 2019 оны жилийн эцсийн хэрэгжилт 46.7, үр дүнгийн үзүүлэлтийн дундаж 55.5 хувьтай үнэлэгдэв.

№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт - 2014 он	Хүрэх түвшин - 2020 он	Хүрсэн түвшин	Үнэл -гээ	2025 он
1	Хөдөө аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 жилийн дундаж өсөлт (хувиар)	12.0	15.0	11.3	<b>40.0</b>	20
2	Нийт төсөвт хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь	2.0	3.0	2.1	<b>40.0</b>	4
3	Нийт сүрэгт үхрийн эзлэх хувь	6.7	8.0	6.7	<b>40.0</b>	10
4	Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах /мянган тонн/	16.8	100.0	31.7	<b>40.0</b>	200

5	Нийт сүү үйлдвэрлэлд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний эзлэх хувь	9.0	30.0	17.0	<b>40.0</b>	50
6	Эргэлтийн талбай /мянган га/	769.0	960.0	870.5	<b>40.0</b>	1050
7	Буудайн га-гийн ургац /центнер/	16.9	17.3	12.9	<b>40.0</b>	20
8	Хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшин (хувиар)	54.0	70.0	40.0	<b>40.0</b>	100
9	Тэжээл үйлдвэрлэлд бүрэн найрлагат тэжээлийн эзлэх хувь	0.7	5.0	23.8	<b>100.0</b>	10
<b>Дундаж үнэлгээ</b>					<b>46.7</b>	

**“ТӨРӨӨС ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫН 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 78.1, ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ 63.6 ХУВЬТАЙ ТУС ТУС ҮНЭЛЭГДЛЭЭ.**

№	Зорилт	Арга хэмжээний тоо	Биелэлт, хувиар
1	I зорилт	<b>17</b>	82.4
2	II зорилт	<b>13</b>	76.9
3	III зорилт	<b>18</b>	65.0
4	IV зорилт	<b>6</b>	90.0
5	V зорилт	<b>18</b>	76.7
6	VI зорилт	<b>8</b>	77.5
<b>Нийт</b>		<b>80</b>	<b>78.1</b>

**ДӨРӨВ. ДҮГНЭЛТ**

1. “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн үнэлгээ 2019 оны жилийн эцсийн байдлаар 46.7 хувь, 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт 78.1 хувь байна.

2. 2018 онтой харьцуулахад 2019 оны хэрэгжилтийн үнэлгээ 29.1 хувиар нэмэгдсэн байна.

3. Бодлогын баримт бичгийн ХШҮ-ний үр дүнгээр өгөгдсөн зөвлөмжийг хариуцсан газар, хэлтэс, мэргэжилтнүүд хэрэгжүүлэх, тайлагнах ажил хангалтгүй байна.

4. Салбарын төсөв, хөрөнгө оруулалт, санхүүжилттэй холбоотой арга хэмжээний хэрэгжилтийн тайлагналт хангалтгүй байна.

5. “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн тодорхой бус байдал нь хүндрэл учруулж байна.

**ТАВ. ЗӨВЛӨМЖ**

1. Тус бодлогын эхний үе шатны хэрэгжилтийн хугацаа 2020 онд дуусах тул хөндлөнгийн үнэлгээ хийлгэх зардлыг шийдвэрлүүлэх, зохион байгуулахыг СХОГ, ХШҮДАГ-т,

2. Хоёр дахь үе шатны зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг холбогдох хууль, журамд нийцүүлэн боловсруулж, 2020 ондоо багтаан батлуулах, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх болон тайлагнах нэгжийг төлөвлөгөөнд бүрэн тусган батлуулахыг НБТГ-т,

3. Хэрэгжилтийн газрууд арга хэмжээний тайлан боловсруулахдаа салбарын мэдээллийг бүрэн авч, нэгтгэн боловсруулахыг тус тус зөвлөмжилж байна.

**ТӨРӨӨС ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН  
ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2019 оны зорилгот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
<b>2.1. Мал аж ахуйн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт</b>						
1	2.1.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, үхэр, хонины аж ахуйг махны чиглэлээр эрчимтэй хөгжүүлж, махны экспортын нөөцийг нэмэгдүүлэх;	2014 - 2020	ЖДҮХС-аас 5.925,5 сая төгрөгийн зээл олгосон		2019 онд Булган аймагт "Шинэ хөдөө" төслийн хүрээнд "Өндөр ашиг шимтэй Сэлэнгэ үүлдрийн бух, Баяд, Цагаан-Уул үүлдрийн хуц, эрчмийн хар үүлдрийн ухна, зохиомол хээлтүүлгийн багаж тоног төхөөрөмж нийлүүлэх" тендерээр "Сэлэнгэ" үүлдрийн үржлийн өсвөр 94 толгой бух, Баяд үүлдрийн үржлийн өсвөр 300 толгой хуц, Цагаан-Уул үүлдрийн үржлийн өсвөр 120 толгой хуц, Эрчмийн хар үүлдрийн үржлийн өсвөр 50 толгой ухныг Булган аймгийн сумдын малчдад хүлээлгэн өгөв. Үүний үр дүнд бэлчээрийн маллагаатай үхэр, хонийг махны чиглэлээр сайжруулах, өсгөн бойжуулах үйл ажиллагаа явуулж байгаа 564 малчин, аж ахуйн нэгжийн малд сайжруулагчаар ашиглах боллоо. Зохиомол хээлтүүлгийн 15 иж бүрдэл тоног төхөөрөмжийг сумдын Хөдөө аж ахуйн тасагт олгосноор зохиомол хээлтүүлгийн явуулын үйлчилгээ хөгжих суурь тавигдлаа. ЖДҮХС-гийн захирлын 2019 оны А/77, А/81, А/117 дугаар тушаалаар арвин ашиг шимтэй махны үүлдрийн үхрийг эрчимжсэн технологиор өсгөж үржүүлэх зорилгоор 14 аймгийн 34 иргэн аж ахуйн нэгжид 5.925,5 сая төгрөгийн зээл олгосон. Үр дүнд нь махны чиглэлийн үхрийн тоо 0.5 пунктаар өссөн байна.	70%
2	2.1.2. Мал аж ахуйн салбарын хөгжил дэх төрийн зохицуулалт, дэмжлэгийн чиглэл, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн үүрэг, хариуцлагын оновчтой тогтолцоог бий болгох;	2014 - 2020			Малын генетик нөөцийн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг 2018 оны 06 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн. Мал аж ахуйн салбарт шинээр хэрэгжсэн 2 хуулийг дагалдан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтан	70%

				ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио, цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус Засгийн газар, УИХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав. "Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих" үндэсний хөтөлбөрийн төслийг Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, мөн өдрийн 400 дугаар тогтоолоор батлагдсан. Тус үндэсний хөтөлбөрийг үндсэн 7 зорилтын хүрээнд 2 үе шаттайгаар 2019-2023 оны хугацаанд 166.3 тэрбум төгрөгийн санжүүжилтийн эх үүсвэрээр хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, холбогдох хэлэлцүүлгийг 4 удаа зохион байгуулж, оролцогчдын саналыг тусгаж, тус төлөвлөгөө ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 120 дугаар тушаалаар батлагдсан.	
3	2.1.3. Малын генетик нөөцийн бүртгэл, төлөв байдлын үнэлгээ, ашиглалт, хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгох, мал аж ахуй эрхлэх уламжлалт хэв маяг, мэдлэгийг хадгалах, баяжуулах;	2014 - 2020	Нийт 397,7 сая төгрөг. Үүнээс Улсын төсөв: 289,5 сая төгрөг. Гадаад төсөл: 40873 USA \$ буюу 108.3 сая төгрөг.	Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлын хүрээнд улсын төсөв болон төслийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэв. 1. ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А-133 дугаар тушаалаар 14 аймгийн 248 сумын 536,0 мянган малд төлөв байдлыг үнэлэх, тодорхойлох ажлыг гүйцэтгүүлэхээр аймгийн ХХААГ-тай гэрээ байгуулж, хавар, намрын технологит хугацаанд Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний 31 нэгжийн 43 ажлын хэсгийн 220 мэргэжилтэн гүйцэтгэв. 2. Малын генетик нөөцийн төлөв байдлыг үнэлэхэд дэмжлэг үзүүлэх нь” ТСР/MON/3707 техник хамтын ажиллагааны төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, 21 аймаг, нийслэлийн 331 сум, 6 дүүрэгт мэргэжил арга зүйн зөвлөгөө үзүүлэх, сургалт зохион байгуулах зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны	70%

				Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А-169 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүд болон малын генетик нөөцийн Үндэсний зөвлөлдөх хорооны гишүүдээс бүрдсэн 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг орон нутагт томилолтоор ажиллав. Орон нутагт зохион байгуулсан энэхүү сургалтад 21 аймаг, нийслэл, 331 сум, 6 дүүргийн мал үржлийн албаны дарга, мэргэжилтэн, хөдөө аж ахуйн тасгийн дарга, мэргэжилтэн, мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийн мэргэжилтнүүд нийт 450 мэргэжилтэн хамрагдсанаар Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлыг зохион байгуулж урьдчилсан тайланг гаргав. Эцсийн тайланг Засгийн газрын нэгдсэн хуралдаан болон Улсын Их Хуралд танилцуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна.	
4	2.1.4. Малын тоо, төрөл, сүргийн бүтцийн зохист харьцааг баримтлах, мал аж ахуйн үйлдвэрлэлийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадавхыг бэхжүүлэх;	2014 - 2020		Мал аж ахуйн үйлдвэрлэлийг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадавхыг бэхжүүлэх зорилгоор Зах зээл ба бэлчээрийн удирдлагын төслөөс Дорнод аймгийн Хөлөнбуйр, Архангай аймгийн Хайрхан, Хэнтий аймгийн Норовлин, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Эрдэнэцагаан, Баруун-Урт сумдад тус бүр нь 110.0 сая төгрөгийн өртөг бүхий 6 ширхэг өвсний саравч, тэжээлийн агуулахыг нийт 660,0 сая төгрөгийн санхүүжилтээр барьж ашиглалтад оруулав. Мөн төслийн хүрээнд хамрагдсан сум тус бүрт 20.0 сая төгрөг, нийт 360.0 сая төгрөгийг өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зориулалтаар олгох асуудлыг ХХААХҮ-ийн Сайдын А-361 дугаар тушаалаар батлуулж, сумдад санхүүжилтийг шийдвэрлүүлсэн нь бүрэлдэхүүн хэсгийн зорилтыг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын ажлуудыг яамны ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж, салбарын бодлого үйл ажиллагаатай нягт уялдуулж зохион байгуулсан нь төсөлд хамрагдсан сум, баг, малчдын тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн. Улсын төсвийн хөрөнгөөр 57, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 297, гадаадын төслийн хөрөнгөөр 60 нийт 414 инженерийн хийцтэй худаг, малчдын санаачлагаар 219 гар худгийг нийт 6,5 тэрбум төгрөгийн	70%

					санхүүжилтээр гаргав. Үүний үр дүнд 840.0 мянган га бэлчээр, 2.2 мянган малчин өрхийн 1.5 сая толгой малын усан хангамжийг нэмэгдүүдэв.	
5	2.1.5. Мал, амьтны үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн явуулж, бүс нутгийн онцлогт тохирсон шинэ үүлдэр, омгийг бий болгон, генийн санг хамгаалах болон малын нөхөн үржүүлгийг сайжруулахад био технологийн ололтыг ашиглах, малын үржүүлэг, технологийн орон нутгийн нэгжүүдийг чадавхжуулах;	2014 - 2020	Улсын төсөв: Малын үзлэг ангилалтад 290.0 сая төгрөг.		2019 онд Үржлийн малд үзлэг, ангилалтад 14 аймгийн бод малын хээлтүүлэгч 2658 толгой, хээлтэгч 53847 толгой, бог малын хээлтүүлэгч 31748 толгой, хээлтэгч 247146 толгой нийт 335399 толгой мал хамрагдав. Ангилалтаар 56,5 мянган толгой бод мал, 278,8 мянган толгой бог мал хамрагдав. Бод малын 20,3 хувь нь цөм сүрэгт, 53,0 хувь нь үржлийн сүрэгт, бог малын 22,4 хувь нь цөм сүрэгт, 54,8 хувь нь үржлийн сүрэгт тус тус ангилагдав. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил /Нэмэлт санхүүжилт/ төслийн хүрээнд 6 аймгийн 6 аж ахуйн нэгжийг дэмжихэд шаардагдах зоо багаж /бод, бог малын жин хэмжих пүү, зохиомол хээлтүүлгийн иж бүрдэл, мал ангилалтын зөөврийн хашаа/-ийн судалгаа гаргаж, 2020 онд төслийн нэгжтэй хамтран олгохоор ажиллаж байна. Малын удмын сангийн үндэсний төв нь иргэн, аж ахуй нэгж, албан байгууллага, гэрээт техникч нарын захиалгын дагуу мах-сүүний чиглэлийн хосолмол ашиг шимт бухны 1455 тун, сүүний үхрийн 305 тун, махны үхрийн 915 тун, эдельбай хуцны 50 тун, нийт 2725 тун гүн хөлдөөсөн үрээр Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгууд болон Улаанбаатар хот орчмын малд зохиомол хээлтүүлэг хийж хамтран ажиллав. Мал үржүүлгийн техникч, аж ахуйн нэгж, фермерүүдийн захиалгын дагуу эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан шаардалгатай үр, шингэн азотыг бэлтгэж өгөв. Тайшир-Өргөө ХХК-ийн гойд ашиг шимт Эдельбай, Меринос, Брышион дучер зэрэг 4 үүлдрийн 6 толгой хуцнаас 4390 тун үр, Сарлагийн бухнаас 260 тун үр, нийт 4650 тун үрийг эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан орчинд, технологийн дагуу авч үндэсний генийн санд хадгалан баяжилт хийсэн. Аймаг, нийслэлийн 12 мал үржүүлгийн техникч нартай гэрээ байгуулж, аймаг, нийслэлийн мал үржлийн алба, сум, дүүргийн Хөдөө аж ахуйн тасгийн холбогдох албан тушаалтнуудтай хамтран захиалгын дагуу, 2018.09.01-нээс 2019.12.01-	70%

					ний өдрийг хүртэлх хугацаанд 2008 толгой бод, 722 толгой бог малын, нийт 2722 толгой малд зохиомол хээлтүүлэг хийж, 2480 литр азот үйлдвэрлэн үйлчилгээнд ашиглав.	
6	2.1.6. Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг хяналтад авах, эрүүлжүүлэх стратегийг бүсчлэн хэрэгжүүлэх, халдварт өвчний тохиолдлыг эрт илрүүлэх, шуурхай хариу арга хэмжээ авах чадавхыг сайжруулах, халдварт өвчингүй тайван байдлыг тодорхой бүс нутгаар баталгаажуулах;	2014 - 2020			Монгол Улсыг үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүлжсэн болохыг Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас баталагаажуулах ажлыг 2018 онд эхлүүлж, 2021 онд баталгаажуулахаар төлөвлөн Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/61 дугаар тушаалаар ажлын хэсгийг байгуулсан. 2018 онд Увс, Завхан, Хөвсгөл, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар аймгаас 580 үхрийн, 887 ямааны цусны ийлдэсний сорьц, уушигны үрэвслийн шинж тэмдэгтэй үхрийн 2 сорьцыг нян судлалын шинжилгээнд тус тус хамруулсан. 2019 онд Мал эмнэлгийн хүрээлэнтэй гэрээ байгуулан санхүүжилтийг шилжүүлсэн. Тус ажлын хүрээнд 3000-аас дээш үхэрт түүвэр байдлаар тандалт хийж байна. Нян судлал, молекул биологийн шинжилгээнд зориулж нийт 9 аймгийн Мал эмнэлгийн газраас үхрийн уушгины эмгэг өөрчлөлттэй сорьц 160, ямааны уушгины сорьц 230 илгээсэн байна. Судалгааны багийн гишүүд 2019 оны 10, 11 саруудад орон нутгаас ажиллаж үхрийн 100, ямааны 188 эмгэгт сорьц цуглуулав. Тандалт судалгааны ажилд үхрээс цуглуулсан 267, ямаанаас цуглуулсан 450 сорьцыг нян судлал болон молекул биологийн судалгаанд ашиглаж байна. “Малын бруцеллэстэй тэмцэх стратеги төлөвлөгөө”, МЭЕГ-ын даргын тушаалаар нийслэл орчмын аж ахуйн нэгж, малчин өрхийн үхэр сүрэгт бруцеллэз, сүрьеэ өвчний тандалт шинжилгээг хийж дээрх өвчнөөс эрүүл аж ахуйн нэгж, малчин өрхийг тодорхойлж сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих замаар нийслэлийн хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангах зорилтыг тавин ажиллав. Тус ажлын тайланг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, бруцеллэзоос эрүүл сүрэгтэн гэрчилгээг олгож байна. Өмнөговь аймгийн мал сүргийг "Малын бруцеллэз өвчингүй, тайван байдал"-ыг тогтоолгох хүсэлт, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн Мал	100 %

					эмнэлгийн газрын "Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн мал сүргийг "Үхрийн сүрьеэ, үхрийн лейкоз өвчнөөр тайванг баталгаажуулаад байна.	
7	2.1.7. Олон улсын жишиг, шаардлагад нийцсэн мал эмнэлгийн албаны үйл ажиллагааны шуурхай, нэгдмэл байдлыг хангасан тогтолцоог сумын түвшин хүртэлх бүх шатанд бүрдүүлэх, орон нутгийн мал эмнэлгийг чадавхжуулж, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагыг өндөржүүлэх;	2014 - 2020			Монгол Улсад Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага /ДМАЭМБ/-с удаа дараа өгсөн зөвлөмж, төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүдэд тусгагдсаны дагуу УИХ-аас 2017 онд “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийг баталж Засгийн газраас 2018 онд “Мал эмнэлгийн ерөнхий газар” (МЭЕГ)-ыг байгуулсан. Мөн ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А/115 дугаар тушаалаар Мал эмнэлгийн ерөнхий газрын бүтэц орон тоог, 2018 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 267 дугаар тогтоолоор аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар болон сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийг шинээр байгуулсан. ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А/174 тоот тушаалаар “Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын бүтэц орон тоо”-г баталснаар Мал эмнэлгийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлсэн байгууллага бий болсон. Мал эмнэлгийн байгууллагын нэгдсэн тогтолцоо бүрдсэнээр МЭЕГ-аас 2019 оны эхний хагас жилд бүх аймаг, 331 сум суурин газар ажиллан малын эмч, үйлчилгээний нэгжийн ажилтнуудад танхимын сургалт хийж, чиглэл, удирдлага, арга зүйн зааварчилгаагаар тасралтгүй хангаснаар тухайн жилдээ малын эмч нар нийт сум, багийн малчид, мал бүхий өрх, ААНБ-д малын эмч мэргэжилтнүүд бүрэн хүрч ажиллаж хуулийг сурталчлах, мал амьтны аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалга, үзлэг вакцинжуулалтын арга хэмжээнүүдийг нийт малын 70 хүртэл хувьд авч хэрэгжүүлсэнээр 2019 онд малын гоц халдварт өвчингүй, тайван байж малчдын орлого нэмэгдэн, худалдааны чөлөөт байдлыг хангахад ихээхэн дэмжлэг үзүүлсэн. Тайлант хугацаанд мал эмнэлгийн гэрчилгээжүүлэлтийн системийг баруун аймгуудад нэвтрүүлснээр мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийг бүрэн хянах, хариуцлагыг сайжруулах үр дүнтэй ажлыг эхлүүлж орон нутаг, хууль	100 %



					хяналтын байгууллагатай хамтран ажиллаж байна. 2019 оны 9 сард ДМАЭМБ-аас экспертийн баг Монголын Мал эмнэлгийн тогтолцоо, хэрэгжүүлж буй үйл ажиллагааг бүх шатанд үзээд хангалттай үнэлэлт өгсөн.	
8	2.1.8. Мал эмнэлгийн үйлчилгээнд зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн дэвшилтэт хэлбэрийг нэвтрүүлэх;	2014 - 2020			Мал эмнэлгийн нэгдсэн системийн сургалтыг 21 аймаг, нийслэлийн мал газрын мэргэжилтнүүд, дүүргүүдийн мал эмнэлгийн тасгийн мал эмнэлгийн улсын байцаагч, тархвар зүйч, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч, хүнсний захуудын дэргэдэх мал эмнэлгийн лабораторийн эмч, мал төхөөрөх болон мах боловсруулах үйлдвэрүүдийн малын эмч нарыг хамруулан зохион байгуулан бэлтгэл ажлыг хангуулсан. Мал эмнэлгийн нэгдсэн системийн гарал үүслийн гэрчилгээний системийн сургалтыг 05 дугаар сарын 1-нээс 21 аймаг болон нийт сумдын мэргэжилтнүүдийг сургалтанд бүрэн хамруулж улмаар нэгдсэн системийг нэвтрүүлсэн. 2019 оны жилийн эцсийн байдлаар мал эмнэлгийн цахим системийг ашиглан 24683 мал эмнэлгийн гэрчилгээ олгогдсон байна. Мал эмнэлгийн нэгдсэн системийг хөгжүүлэн, малын шилжилт хөдөлгөөнийг хянаж, түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлж улмаар 2020 оны мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.	100 %
9	2.1.9. Эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд эзэмшүүлснээс бусад бэлчээрийг төрийн эрх бүхий байгууллагын хяналт, зохицуулалттайгаар ашиглуулах, эрчимжсэн мал аж ахуйд тэжээл тариалах зориулалтаар тариалангийн газрыг ашиглуулах;	2014 - 2020			Эрчимжсэн мал аж ахуйд тэжээл тариалах зориулалтаар тариалангийн газрыг ашиглуулах зорилгоор Төв аймгийн Борнуур, Сүмбэр сумын бэлчээр ашиглагчдын хэсгийн малчид “Тайшир өргөө” ХХК-тай нийт 60 га талбайд хамтран ажиллах гэрээ 2018 онд байгуулж, Борнуур суманд 30 га талбайд холимог ногоон тэжээл, 5 га талбайд царгас, Сүмбэр суманд 30 га талбайд холимог ногоон тэжээл, 5 га талбайд царгас тариалав. Компаниас олон наст тэжээлийн ургамал болох царгасны сайн чанарын үрээр хангаж, техник технологийн тусламжтай үрийн нормыг тооцоолон тариалалт хийв. 30 га холимог ногоон тэжээл тариалсан талбайгаас нийт 28 тн тэжээл (0,6ц/га) хураан авч, 10 тн дарш бэлтгэж, 18 тн-ийг БАХ-ийн малчдад хуваарилан олгосон.	70%

					Хураан авсан ногоон тэжээлээс үлдсэн 731 боодлыг аймгийн фондод хүлээлгэн өгч, 330 боодлыг жил хадгалсан учир сумын тэжээлийн үйлдвэрт өгсөн. Борнуур сум 4 хэсэг газар нийт 30 га талбайд тариалалт хийж, нийт 84.6 тн ногоон тэжээл хураан авсан. Улсын хэмжээнд 2019 онд 124,0 мянга тн ногоон тэжээл хураан авч өмнөх оноос 30,0 мянган тн-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	
10	2.1.10. Бэлчээр болон байгалийн бусад нөөцийн зохистой ашиглалт, бэлчээрийн газар зохион байгуулалт, төлөвлөлт, удирдлагын тогтолцоог сайжруулах, отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх;	2014 - 2020			Бэлчээрийн ургамал хөнөөл учруулж буй үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг өргөн хүрээнд зохион байгуулах тухай Засгийн газрын 2019 оны 185 дугаар тогтоол гаргуулж, жил бүрийн 5 дугаар сарын эхний долоо хоног болон 10 дугаар сарын сүүлийн 7 хоногийн Баасан, Бямба, Ням гарагийг “Бэлчээр хамгаалах өдөр” болгон зарлав. Дундговь, Сүхбаатар аймагт олон нийтийн оролцоотойгоор үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг бэлчээрийн 25 га-д зохион байгуулав. Байгалийн нөөц болон бэлчээрийг зохистой ашиглаж, бэлчээрийн доройтлыг бууруулах, отрын нөөц бэлчээр бий болгох ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, гадаадын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр хийж гүйцэтгэн нийт 42,2 мян.га бэлчээрийг хашиж, 494,6 мян га бэлчээрийг сэлгэн өнжөөж сайржуулав.	100 %
11	2.1.11. Бэлчээрийн даац, төлөв байдлын үнэлгээнд тулгуурлан малын тоо, төрөл, сүргийн бүтцийг тохируулах эдийн засгийн хөшүүрэг бий болгох, бэлчээрийг оновчтой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;	2014 - 2020			Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын Баян нурууны отрын бүс нутгийн 102,5 мянган га бэлчээрийн талбайн төлөв байдлын үнэлгээ хийж гүйцэтгэв. ХХААХҮ-ийн сайд, БОАЖ-ын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019 оны тушаалаар Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлалыг батлуулав. Баян-Өлгий аймгийн холбогдох мэргэжилтнүүдэд Бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлалын сургалтыг зохион байгуулав. Аймаг дундын отрын бүс нутгийн Завхан, Говь-Алтай, Булган, Говьсүмбэр аймгийн 2019-2021 оны бэлчээр ашиглалт, хамгаалалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, зураглалыг батлуулсан. Бэлчээр ашиглалтын 53 малчдын бүлгийг бэхжүүлэх, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хийлгэх сургалт семинарыг Сүхбаатар, Дундговь аймгийн сумдын малчдын	70%

				<p>бүлгүүдэд 2019 оны 3 сард ТББ зохион байгуулсан. Сургалтад 166 малчдын бүлгийн төлөөлөл оролцсоноос эмэгтэй төлөөлөл 64 хүн байна. ЗДТГ-ын ажилтнууд, төсөл удирдах ажлын хэсэг, багийн удирдлага, малчдын бүлгийн ахлагч, малчдын төлөөллийг оролцуулсан сургалтыг 2019 оны 3 сард сумдад нийт 405 хүнд зохион байгуулснаас 169 эмэгтэй оролцогсод байсан. Архангай, Өвөрхангай, Хэнтий, Дорнод аймгуудын сумдад бүлэг байгуулах, бэхжүүлэх зорилгоор сумдын удирдлага, төсөл удирдах ажлын хэсэг, багийн засаг дарга нар болон малчдын төлөөлөлд сургалтыг 2019 оны 5 сард зохион байгуулж, сум тус бүрд 1-3 бэлчээр ашиглалтын малчдын бүлэгт үзүүлэх загвар сургалтыг зохион байгуулж, 877 хүн хамрагдснаас эрэгтэй 419, эмэгтэй 458 оролцогч байсан. МАА-н үйлдвэрлэлийн болон бэлчээрийн менежмент, бэлчээрийн менежментийн 3 жилийн төлөвлөгөө боловсруулах, малын даатгал, малчдад санхүүгийн мэдлэг олгох зэрэг сургалтуудыг бүрэлдэхүүн хэсэгт хамрагдсан хөдөөгийн 18 суманд 1045 малчныг хамруулан ТББ-аас 2019 оны 7, 8 саруудад зохион байгуулснаас эмэгтэй 503, үүнээс 35 хүртэлх насны залуучууд 251 хүн хамрагдсан байна. Хоршооны сургалт 5 аймгийн 16 сумдын аймаг хариуцсан ажилтан, төслийн ажилтан, багийн ЗД нар, малчдын төлөөлөл 134 хүнийг хамруулан зохион байгуулав.</p>	
12	2.1.12. Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж байгаа мэрэгч амьтан, шавжтай тэмцэх арга хэмжээг байгаль орчинд халгүй, дэвшилтэт арга технологи ашиглан өргөжүүлэх;	2014 - 2020	Нийт 3.7 тэрбум төгрөг. Үүнээс Улсын төсвийн 3.1 тэрбум төгрөг. Орон нутгийн төсвийн 570 сая төгрөг.	<p>Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг 2019 онд өргөн хүрээтэй бүх нийтийн ажил болгон зохион байгуулах зорилгоор Засгийн газрын 185 дугаар тогтоолоор жил бүрийн 5 дугаар сарын эхний долоо хоног болон 10 дугаар сарын сүүлийн 7 хоногийн Баасан, Бямба, Ням гарагийг “Бэлчээр хамгаалах өдөр” болгон зарласан. Энэ ажилд нийт 15 аймгийн 135 сум, 3 аймаг дундын отрын бүс нутгийн 1.3 сая га бэлчээрийн талбай хамрагдаж үлийн цагаан оготны хөнөөлөөс хамгаалж мал аж ахуйн үйлдвэрлэлд ашиглах боломжийг бүрдүүлж ажиллаа. Ингэснээр эрдэм шинжилгээний байгууллагаас гаргасан нийт тэмцэх</p>	100 %

					шаардлагатай талбайн 24.3 хувьд тэмцэх ажил зохион байгуулснаараа онцлог байлаа. Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг 2019 оны гүйцэтгэл нь өмнөх оноос 307 мянган га, сүүлийн 10 жилийн дундажаас 476 мянган га талбайгаар тус тус нэмэгдсэн байна. Үлийн цагаан оготны бэлчээрт учруулах хөнөөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажилд 2019 онд улсын төсвийн 3.1 тэрбум, орон нутгийн төсвийн 570 сая нийт 3.7 тэрбум төгрөг зарцуулав. Бэлчээр хамгааллын ажилд орон нутгийн төсвөөс зарцуулж буй хөрөнгө нэмэгдэж, малчид, иргэдийн оролцоо сайжирч байгаа нь нутгийн удирдлага, малчид иргэдийн бэлчээр нутгаа хамгаалах, нөхөн сэргээх сонирхол дээшилж бэлчээрийн үнэ цэнийг ойлгож байгаагийн илрэл гэж үзэж байна.	
13	2.1.13. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, цас борооны ус тогтоох, усан сан, нуур, хөв, цөөрөм байгуулах, сэргээгдэх эрчим хүч ашиглах малчид, иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжих;	2014 - 2020	Нийт 6.5 тэрбум төгрөг. Үүнээс: Улсын төсвийн 1.2 тэрбум төгрөг, гадаадын төсөл, хөтөлбөрийн 1.2 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн 4.1 тэрбум төгрөг		Энэ онд улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 57, гадаадын төсөл, хөтөлбөрийн 1.2 тэрбум төгрөгөөр 60, орон нутгийн төсвийн 4.1 тэрбум төгрөгөөр 297 инженерийн хийцтэй худаг, малчдын өөрсдийн санаачлагаар 219 гар худаг, нийт 6.5 тэрбум төгрөгөөр 414 инженерийн хийцтэй худаг гаргасан. Үүний үр дүнд 840.0 мянган га бэлчээр, 2.2 мянган малчин өрхийн 1.5 сая толгой малын усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ болсон. 2019 онд НҮБ-ын “Уур амьсгалд ухаалаг мал аж ахуй” төслийн хүрээнд Хэнтий аймгийн Цэнхэрмандал сум, Төв аймгийн Батсүмбэр, Дундговь аймгийн Луус суманд инженерийн хийцтэй 3 худаг шинээр гараж, нарны эрчим хүчээр ажиллах ус өргүүр суурилуулж ашиглалтанд оруулав. Мөн Өмнөговь аймгийн орон нутгийн төсвийн 361,5 сая төгрөгийн хөрөнгөөр 15 сумын 26 багт инженерийн хийцтэй 30 худагт нарны эрчим хүчээр ажиллах ус өргүүр суурилуулж 164 өрхийн малчдын хөдөлмөр хөнгөвчилж, 121,4 мян толгой малын усан хангамжийг бүрдүүллээ.	100 %
14	2.1.14. Малын тэжээл, био бордоо, сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тэдгээрт дэвшилтэт техник,	2014 - 2020			Малын протейн тэжээлийн дэвшилтэд тоног төхөөрөмж, технологи бүхий үйлдвэр 2019 онд Улаанбаатар хотод ашиглалтад орсон. Тус үйлдвэр ашиглалтад орсноор өдөрт малын гаралтай 96 тонн хаягдал түүхий эд боловсруулж, 24 тонн тэжээлийн	70%

	технологи нэвтрүүлэх, нутагшуулах;				уураг, 17 тонн малын гаралтай тос үйлдвэрлэх хүчин чадалтай юм.	
15	2.1.15. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн нөөцөд түшиглэсэн боловсруулах үйлдвэр, цехийг бүсчилж хөгжүүлэх;	2014 - 2020			Бүгд Найрамдах Беларусь улсын экспортын зээлийн хүрээнд манай улсын газар тариалангийн бүс нутагт сүүний чиглэлийн цэвэр үүлдрийн үхрийн иж бүрэн цогцолбор ферм байгуулахаар ХХААХҮЯ-аас төслийн баримт бичиг боловсруулан ажиллаж байна. Уг төсөл хэрэгжсэнээр олон улсын стандартын шаардлага хангасан цогцолбор сүүний чиглэлийн эрчимжсэн ферм байгуулагдаж сүү боловсруулах үйлдвэрт шингэн сүү нийлүүлж, дотоодын зах зээлд эрүүл аюулгүй сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангахад чиглэгдэнэ. Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ тодорхой хувиар өсөж, өвлийн улирлаас хамаарсан сүүний нийлүүлэлт нэмэгдэх ач хобогдолтой.	40%
16	2.1.16. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг түүний чанар, аюулгүй байдалтай уялдуулах;	2014 - 2020			Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг түүний чанар, аюулгүй байдалтай уялдуулах зорилтын хүрээнд УИХ-ын 2012 оны 74 дүгээр тогтоол “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай”, ЗГ-ын 2013 оны 394 дүгээр тогтоолоор баталсан “Журам шинэчлэн батлах тухай”, тогтоолын хоёрдугаар хавсралт “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ыг батлан хэрэгжүүлж байна. 2018 онд малчин, мал бүхий 39263 иргэнд 22,289.0 мянагн ширхэг арьс ширний урамшуулалд 9,462 сая.төг олгосон. Арьс ширэний түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулж, чанар, аюулгүй байдалтай уялдуулах, мөшгих тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А-333 тушаалаар байгуулан	100 %

					ажиллаж байна. Засгийн газрын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 343 дүгээр тогтоолоор “Хонь, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт нийлүүлсэн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох” журмыг шинэчлэн батлуулсан. Шинэчилсэн журмаар боловсруулах үйлдвэрийн шат дамжлагыг тодорхой болгосон, сайн чанарын ноос буюу хэвийн үргэлж ноосонд урамшуулал олгохоор тусгасан. Мөн боловсруулах үйлдвэр, холбоодын үүрэг хариуцлагыг дээшлүүлж, хяналтын тогтолцоо, урамшуулал олгох үе шат, хугацааг тодорхой болгож, санхүүгийн тайлан, татварын тайлан, ажлын байрыг нэмэгдүүлсэн зэрэг нотлох баримтыг үндэслэн Үндэсний үйлдвэрүүдийн санхүүгийн хяналтыг сайжруулах заалтууд орсон. Түүнчлэн урамшууллын хэмжээг хонины ноосны килограм тугамд 1500 төгрөг болгон нэмэгдүүлсэн.	
17	2.1.17. Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн бага ашиглалттай байгаа нөөцийн (дотор мах, дайвар бүтээгдэхүүн, хонь, ямаа, ингэний сүү гэх мэт) боловсруулалтыг нэмэгдүүлэх.	2014 - 2020			Мах сүүний анхдугаар аяны хүрээнд 2019 онд Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд жишиг сүүний үйлдвэр байгуулах “Витафит милк” ХХК-ийн санаачилсан төслийг бодлогоор дэмжиж, үүний үр дүнд хоногт 5 тн сарлагийн шингэн сүү боловсруулах хүчин чадалтай загвар 2 үйлдвэр ашиглалтад орсон. Баянхонгор аймгийн Баянлиг суманд “Их халбагант” ХХК өдөрт 400 литр сүү үйлвэрлэх хүчин чадалтай ингэний сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг цех ашиглалтад оруулан үйл ажиллагаа явуулж байна.	100 %
3.1. Тариалангийн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт						
18	3.1.1. Тариалангийн газрыг эдийн засгийн эргэлтэд бүрэн оруулж, үр ашигтай ашиглах, бүртгэл, хяналтыг сайжруулах, тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжсэн мал аж ахуйтай хослон хөгжүүлж, тэдгээрийг эрхлэх бүс нутгийг тогтоох;	2014 - 2020			Тариалангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт “Тариалангийн бүс нутаг, түүний заагийг тогтоох асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг харгалзан тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ” гэж заасны дагуу Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Булган, Архангай, Өвөрхангай, Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн эхний ээлжинд дээрх 7 аймгийн материалыг эцэслэн	100 %

					<p>боловсруулж Засгийн газрын 2018.05.16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 131 дүгээр тогтоолоор батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж байна. Бүс нутаг тогтоолгох асуудлаар Хөвсгөл, Увс аймгаас материал ирсэн боловч бүрдэл дутуу гэдэг шалтгаанаар буцаагдсан болно. Дорнод, Сүхбаатар аймгаас материал ирээгүй байна. Тариалангийн зарим бүс нутгийг тогтоох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 131 дүгээр тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, орон нутгийн хөгжлийн бодлого, аймаг, сумын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан Тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг зохистойгоор хослон эрхлэх боломжийг бүрдүүлэх, орон нутгийн Төрийн захиргааны байгууллагууд болон мэргэжлийн Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг идэвхижүүлэх зорилгоор Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулан танилцуулж Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 05 дугаар сард 02 дугаар албан даалгаврыг гаргуулан орон нутагт хүргүүлж хэрэгжилтийг зохион байгуулж байна.</p>	
19	3.1.2. Төвийн бүсэд тариалангийн газрын боломжит орон зайн ашиглалтыг сайжруулах, баруун, зүүн бүсэд атаршсан газрыг эргэлтэд оруулах;	2014 - 2020			<p>2016 оны байдлаар Завхан аймаг нийт эргэлтийн талбай 60,5 мянган га, үүнээс атаршсан 55,7 мянган га. Булган аймаг нийт эргэлтийн талбай 119,8 мянган га, Үүнээс атаршсан 43,4 мянган га, Дархан-Уул аймаг нийт эргэлтийн талбай 36,3 мянга га үүнээс атаршсан 2,1 мянган га, Хэнтий аймаг нийт эргэлтийн талбай 75.9 мянган га, үүнээс атаршсан 44,8 мянган га, Говь-Алтай аймаг нийт эргэлтийн талбай 5,1 мянган га үүнээс атаршсан 4,4 мянга га талбай тус тус байсан. 2019 оны байдлаар Завхан аймаг 1,1 мянган га талбайг эргэлтэнд оруулснаар атаршсан талбай 54,6 мянган га, Говь-Алтай аймаг 0,6 мянган га талбайг эргэлтэнд оруулснаар атаршсан талбайн 3.8 мянган га, Хэнтий аймаг 4,2 мянган га атаршсан талбайг эргэлтэнд оруулснаар атаршсан талбай 40,6 мянга га, Булган аймаг 15,1 мянган га талбайг эргэлтэд оруулснаар атаршсан талбай 28,3 мянган га, Дархан-Уул аймаг атаршсан талбайг нэмж эргэлтэд оруулаагүй бөгөөд</p>	100 %

					атаршсан талбайн мэдээллийг аймаг сум бүрээр нь гаргаж мэдээллийн архивын санд хадгалав. Дархан-Уул, Төв, Хэнтий, Булган, Говь-Алтай, Завхан аймагт 2016 оноос хойш нийт 42,0 мянган га атаршсан талбай эргэлтэд тус тус оруулаад байна.	
20	3.1.3. Хөрс боловсруулах тэг элдэншүүлгийн технологийг үйлдвэрлэлд үе шаттайгаар бүрэн нэвтрүүлэх болон тариалангийн газрын хөрсийг салхи, усны элэгдэл, эвдрэлээс хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх;	2014 - 2020			Монгол Улсын Хөгжлийн банкны “Ди Би Эм Лизинг” ХХК-тай хамтран ОХУ-ын Внешэкономбанкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Газар тариалангийн техникийн шинэчлэл” төслийн хүрээнд ОХУ-ын Внешэконом банкны 3.0 сая еврогийн хөнгөлөлттэй зээлээр хөрөнгөөр тэг элдэншүүлгийн технологид нийцсэн талбайд сүрэл хэрчиж цацах зориулалттай 2 төрлийн хүчин чадлын 36 ширхэг үр тариа хураах комбайн нийлүүлсэн. Нийлүүлсэн техникийг ХХААХУ-ийн Сайдын “Техник, тоног төхөөрөмжийг дамжуулан түрээслэх үнэ, нөхцөл тогтоох тухай” 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А-288 дугаар тушаалын дагуу 30 хувийн урьдчилгаа төлбөртэй 4 жилийн хугацаатай лизингээр олгосон. Тус төслийн хүрээнд 2017-2019 онуудад 105 ширхэг үр тариа хураах комбайн нийлүүлэгдэж 60.0 мянган га талбайн үр тариаг технологийн хугацаанд хураах техник шинээр үйлдвэрлэлд нэвтэрсэн. Тариалангийн газрын хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах зорилгоор Хүнс, хөдөө аж ахуйн газрын саналыг үндэслэн 2019 онд улсын төсвийн хөрөнгийн 3.0 тэрбум төгрөгөөр Дархан-Уул аймгийн Хонгор суманд 27 км, Дорнод аймгийн Халх гол суманд 45.0 км, Орхон аймгийн Жаргалант суманд 15.0 км, Төв аймгийн Жаргалант суманд 50.0 км, Борнуур суманд байрлах Хөдөө аж ахуйн их сургуулийн судалгаа шинжилгээний Нарт төвд 4.07 км, Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 40.0 км, Хүдэр суманд 10.0 км, Орхон туул суманд 30.0 км, Баруунбүрэн суманд 10.0 км, Хушаат суманд 10.0 км, Зүүнбүрэн суманд 20.0 км, Баянгол суманд 50.0 км, Хөвсгөл аймгийн Тариалан суманд 20.0 км, Хэнтий аймгийн Хурх суманд 71.85 км, Биндэр суманд 21.0 км нийт 424.0 км хашаа барих ажлыг зохион байгуулсан.	70%



21	3.1.4. Таримлын сэлгээний ээлжийн тоог нэмэгдүүлж, цулгуй уриншийн хэмжээг бууруулах, эрчимжсэн мал аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн түүхий эдийн хангамж, гадаад зах зээлийн хэрэгцээнд тулгуурлан таримлын зохистой сэлгээг мөрдөж, сэлгээнд тариалсан ашигт таримлыг зах зээлд нийлүүлэхийг дэмжих;	2014 - 2020			2019 оны тариалалтад зориулан ТЭДС нь Ургамал газар тариалангийн хүрээлэнгээс улаанбуудайн Дархан 144 сортын элит үр 240 тонн, бусад аж ахуйн нэгж, иргэдээс нутагшсан чанар сайтай Дархан 131, Алтайская 75, 325, Бурядская остистая, Сэлэнгэ сортын үр 4741 тонн, нийдээ 4981 тонн үрийн нөөц бүрдүүлж 122 аж ахуйн нэгж иргэнд, Онцгой байдлын ерөнхий газар 5474 тонн үрийг 121 аж ахуйн нэгж иргэнд, нийтдээ 2019 оны тариалатад зориулан 243 аж ахуйн нэгж, иргэнд 10.2 мянган тонн буудайн үрийг 30 хувийн урьдчилгаатай зээлээр олгож дэмжлэг үзүүлэв. 2019 оны ургацаас чанар сайтай сортын үрийн нөөц бүрдүүлэх зорилгоор хүсэлт гаргасан 10 аймгийн 186 аж ахуйн нэгжийн 29.1 мянган га талбайд сортын хянан баталгааг хийлгэж нэгдсэн дүнг холбогдох мэргэжлийн байгууллагуудад хүргүүлэн үрийн нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулснаар ТЭДС-д 5 сортын 3.1 мянган тонн үрийн нөөцийг бүрдүлэв. Түүнчлэн 2020 онд улсын төсвийн 5.0 тэрбум төгрөгөөр 5.0 мянган тонн элит үр импортоор нийлүүлэх ажлыг зохион байгуулж байна. Мөн энэ онд тэжээлийн таримлын үрийн нөөц бүрдүүлэх, тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор тэжээлийн вандуйн нутагшсан сортын үрийг “Элит үр” ХХК-ийн дэмжлэгтэйгээр жил бүр 20 га-д тариалж үржүүлж байгаагийн зэрэгцээ ОХУ-ын Алтайн хязгаараас 2018 онд тэжээлийн хошуу будааны 160 тонн үрийг тариалан бүхий аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтээр нийлүүлж үржүүлэн жил бүр 350-500 тонн тэжээлийн хошуу будаа, вандуйны үрийг дотоодын зах зээлд нийлүүлэх боломжийг бүрдүүлснээр сүүлийн 2 жилд тэжээлийн таримлын тариалалт 14.0-15.0 мянган га-гаар нэмэгдэж 2019 онд 36.0 мянган га-д хүрэв.	70%
22	3.1.5. Эдийн засгийн үр ашигтай, хөрсний үржил шимд ээлтэй таримал, сортыг нутагшуулах, бүс нутгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон	2014 - 2020			Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 20 дугаар тэмдэглэл гаргуулав. Мөн хуулийн төслийг хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу бүрдүүлбэрийг хангаж, 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдөр	70%

	ирээдүйтэй, баталгаажсан таримлын үрийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн үрээр хангах, үр, сортын тариалан, үрийн аж ахуйн тогтолцоог сэргээн хөгжүүлэх;				хүргүүлснээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн. Улсын сорт сорилтын хурлаар 2019 онд сорт сорилтод үр тарианы 4 сорт, хүнсний ногооны 6 сорт, төмсний 1 сорт, ирээдүйтэй сортоор үр тарианы 2 сорт, хүнсний ногооны 4 сорт, нутагшсан сортоор үр тарианы 2, хүнсний ногооны 2 сортыг батлав. 2019 онд хүнсний ногооны бууцайны Матадор, цэсний Чёрная красавица сортууд нутагшсан сортоор батлагдлаа. Төмсний вирусгүй бичил булцуу 180.0 мянган ширхэг, супер элит үр 50 тн, элит үр 500 тн-ыг үйлдвэрлэв. Хүнсний ногооны шар лууван 4055 кг, шар манжин 2502 кг, хүрэн манжин 1297 кг, сармис 1000 кг үрийн нөөц дотоодоос үйлдвэрлэлээр бүрдүүлэв. Таримал ургамлын үрийн салбарын хөгжлийг дэмжих, үрийн аж ахуйн тогтолцоог хөгжүүлэх зорилгоор Таримал ургамлын үр сортын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ төслийг боловсруулан, үзэл баримтлалыг батлуулан 2019.06.07-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр тогтсон. Засгийн газрын 2019 оны 80 дугаар тогтоолоор Газар тариалангийн хөгжлийн бодлого зохицуулалтын газарт хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтсийг 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлээд байна.	
23	3.1.6. Хөрсний бүтэц, үржил шимд сөрөг нөлөөгүй дэвшилтэт технологид суурилсан машин, тракторыг сонгож парк бүрдүүлэх, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлд нэвтрүүлэх, техникийн засвар үйлчилгээний тогтвортой сүлжээ	2014 - 2020			БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих” төслийн хүрээнд нийт 7.6 сая ам. долларын хөрөнгөөр 50-165 м.х-тэй трактор 186 ширхэг, хадлангийн зориулалттай 40 иж бүрдэл техник, таримал тэжээл үйлдвэрлэлийн зориулалттай 7 төрлийн 136 техник нийлүүлэгдсэнийг хүлээн авсан. Нийлүүлэгдсэн трактор, техник, тоног төхөөрөмжийг ХХААХҮ-ийн Сайдын 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А-139 дүгээр	70%

	байгуулах, зарим машин, багаж, эд ангийг дотооддоо үйлдвэрлэх, угсрах үйл ажиллагааг дэмжих;				тушаалаар 10 хувийн урьдчилгаатай, 8 жилийн хугацаатай, жилийн 2 хувийн хүүтэй лизингээр олгож байна. 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 2 сая 275 мянган ам. долларын үнийн дүн бүхий 6 төрлийн 57 трактор, 8 нэр төрлийн 82 ширхэг техникийн шалгуур хангасан иргэн, ААН-д лизингээр олгосон.	
24	3.1.7. Усны хайгуул, судалгаанд тулгуурлан гадаргын болон бороо, цасны усыг хуримтлуулах, усалтын системийн ашиглалтыг сайжруулах, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх;	2014 - 2020			Ховд аймгийн Зэрэг, Булган, Үенч, Буянт сумдын 4 усалтын системийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барьж, сэргээн засварлаж усалгаатай тариалангийн эргэлтийн талбайн хэмжээг 767 га-аар нэмэгдүүлээд байна. БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих” төслийн хүрээнд үр тариа, төмс хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлдэг 13 аж ахуйн нэгж, 1 иргэнд 35 ширхэг усалгааны тоног төхөөрөмжийг 12 жилийн хугацаатай зээлээр олгож усалгаатай тариалангийн эргэлтийн талбайг 3000 га-аар нэмэгдүүлснээр нийт 3767 га талбай шинээр ашиглалтад орох боломж бүрдсэн. Үүний үр дүнд усалгаатай тариаланд ашиглах боломжтой талбайн хэмжээ 57,4 мянган га талбайд хүрэв.	70%
25	3.1.8. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтад ус, эрчим хүчний зарцуулалт багатай, байгаль орчинд халгүй дуслын болон хөрсөн доороос нэвчүүлэх усалгааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;	2014 - 2020			“Шинэ хөдөө Булган” төслийн хүрээнд төмс, хүнсний ногооны услах зориулалт бүхий 15 ширхэг буюу 150 га услах хүчин чадал бүхий 10 га-ийн усалтын системийг 12 суманд суурилуулсан. Дархан-Уул аймаг: Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих” төслийн хүрээнд төмс хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлдэг иргэн Д.Хадбаатар 75 га талбайг услах хүчин чадалтай бороожуулагчийг 12 жилийн хугацаатай зээлээр олгосон. Хэнтий: Төмс хүнсний ногооны үйлдвэрлэлд зориулж Жаргалтхаан сум 1, Дархан сум 1 худаг, Цэнхэрмандал сум 2 худаг, Биндэр суманд 2, Норовлин суманд 1, Баян-Адарга суманд 1, Батширээт 1 худаг гаргаж, Мөрөн суманд 1 усалгааны шуудуу шинэчлэн засварлаж нийт 10 худаг гаргасан. БХ: Аймгийн Засаг даргын дэмжлэгээр Бумбат, Герман толгой зэрэг газруудыг	100 %

					<p>нэгдсэн цахилгаан эрчим хүчинд холбосноор 48 га талбайг усжуулах эдийн засгийн хэмнэлттэй төслийг хэрэгжүүлж суваг, шуудуугаар усалгаагаа хийж ногоо тарьдаг 56 өрхийн усалгааны асуудлыг шийдвэрлэсэн. Ховд: Булган, Үенч Ховд Зэрэг суманд нийт 1,3 тэрбум төгрөгөөр төмс, хүнсний ногоог услах зориулалт бүхий усалтын системийг сэргээн засварлах ажил хийгдэж сум орон нутагт хүлээлгэн өгсөн. Эдгээр усалтын систем бүрэн хэмжээгээр ашиглалтанд орсоноор төмс, хүнсний ногооны 230 га талбайн усан хангамж сайжрах боломж бүрдсэн. Говь-Алтай: Шарга сумын Урд голын усалтын системийн толгойн барилгын даланг сэргээн засварласанаар хүнсний ногооны талбайн хэмжээг 5 га-аар нэмэгдүүлж нийт 50 га-д тариалах боломж бүрдсэн.</p>	
26	3.1.9. Ургамлын өвчин, хортон шавж, хог ургамал, мэрэгч амьтны тархалт, хор хөнөөлийн судалгаанд тулгуурлан химийн гаралтай бордоо, ургамал хамгааллын бэлдмэлийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтыг төлөвшүүлэх;	2014 - 2020			<p>2019 онд Улсын төсвийн хөрөнгөөр “Зүүн бүсийн Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн тариалангийн талбайн хөнөөлт организмын тархалт, зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох, судалгаа хийх, тэмцэх арга хэмжээг боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэх гэрээг Ургамал хамгааллын тухай хууль болон Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын Хүрээлэнгүүдийн чиг үүргийг батлах тухай 2015 оны тушаалд заасны дагуу ТНБД-ын 2019 оны 07 сарын 02-ны өдрийн А-284 дүгээр тушаалаар 2019 оны 7 сарын 23-ны өдөр 190723/05/259 дугаартай гэрээг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй байгуулсан. Тус хүрээлэн нь тариалангийн талбайн таримлын өвчин, хортон шавьж, хог ургамал, мэрэгчийн тархалт, тэдгээрийн ургацад учруулж буй хөнөөлийн талаархи дэлгэрэнгүй судалгааг гэрээнд заасан шаардлагын дагуу гүйцэтгэж, цаашид авч хэрэгжүүлэх заавар зөвлөмжийг аймаг тус бүрээр гарган ажлын тайлан болон гэрээний ажлын даалгаварт заасан бусад зурагт хуудас, хөнөөлт организмын талаарх каталоги зэргийг тус яамны Газар тариалангийн чиглэлээр бараа, ажил, үйлчилгээ ажил хүлээн авсан акт үйлдэн гэрээ дүгнэсэн тэмдэглэлийг гарган Санхүү, хөрөнгө оруулалтын газар хүлээлгэн өгсөн. Энэхүү</p>	70%

				судалгааны үр дүнд үндэслэн тариалангийн талбайн хөнөөлт организмтой байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологи, ургамал хамгааллын цогц аргыг ашиглан тэмцэх арга хэмжээг боловсруулан гаргасан. Мөн НҮБ-ын ХХААБ-аас санхүүжүүлж буй “Монгол ногоо” төслийн 4 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн багтай хамтран 2019 оны 12 сард “Хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх сургагч багш нарыг бэлтгэх ” сургалтыг зохион байгуулсан ба нийт 127 хүн хамрагдсан бол “Ургамал хамгааллын цогц аргыг нэвтрүүлэх” сургалт болон сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг 2019 оны 12 сарын 16-17-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж 45 хүнийг хамруулсан.	
27	3.1.10. Жимс, жимсгэний тариалалт, нэр төрлийг нэмэгдүүлэх;	2014 - 2020		Улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Булган, Жаргалант суманд жимс, жимсгэний суулгац үржүүлгийн төвийг анх удаа байгуулав. Тус яамны захиалгаар 120 сая төгрөгийн санхүүжилтээр “Жимсний селекцийн судалгаа, ирээдүйтэй сортын суулгац үржүүлэг” ШУТ-ийн төслийг Ургамал газар тариалангийн хүрээлэнд 2 дахь жилдээ хэрэгжүүлэв. 2019 онд улсын төсвийн 147.4 сая төгрөгийн улсын төсвийн санхүүжилтээр суулгац үржүүлэх болон хүнсний ногоо тариалах 120 м <sup>2</sup> талбай бүхий 38 иж бүрдэл нийлэг хальсан хүлэмж нийлүүлж суулгац үйлдвэрлэл 200.0 мянган ширхэгээр, хүлэмжийн талбай 3360 м <sup>2</sup> -аар нэмэгдэх боломж бүрдүүлэв. Булган аймагт хэрэгжүүлж буй Шинэ хөдөө төслийн хүрээнд 239.2 сая төгрөгийн санхүүжилтээр 7 суманд тус бүр 10 га талбай бүхий нийт 70 га талбайд жимс жимсгэний дуслын усалгааны төхөөрөмж нийлүүлж суурилуулав. Тус төслийн хүрээнд сүүлийн 2 жилд 8 суманд жимст цэцэрлэгийн талбай байгуулан нийт 50 мянган ширхэг чацаргана, 15.0 мянган ширхэг үхэр нүдний суулгац зээлээр олгон тариалуулав. Азийн хөгжлийн банкны 945.3 сая төгрөгийн санхүүжилтээр чацарганы үрийн тосыг орчин үеийн өндөр технологийн нүүрсхүчлийн хийгээр хандлах аргаар ялгаж авах тоног төхөөрөмжийг ШУТИС-д	70%

					суурилуулан олон улсын стандартад нийцсэн үрийн тосыг гарган авч судлах, экспортыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэв. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2019 онд Мон-адонис ХХК-ийн “Жимс жимсгэний хуурай ханд үйлдвэрлэх” төсөлд 155.4 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгов. 2019 онд 519 аж ахуйн нэгж, 5289 иргэн 6528.2 га талбайд жимс жимсгэнэ тариалж 2604.1 тонн жимсний ургац хураан авсан байна. Энэ нь 2016 оноос тариалсан талбай 456 га талбайгаар, хураан авсан ургац 45 тонноор нэмэгдсэн байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймаг, орон нутгаас 3.7 тэрбум төгрөгийн хөрөнгө зарцуулж 410 ажлын байр шинээр бий болгож, 7 төрлийн жимсний 515.3 мянган ширхэг суулгацыг дотооддоо үйлдвэрлэсэн байна.	
28	3.1.11. Үр тариа, буурцагт болон бусад таримлын төрөл, сортыг нэмэгдүүлэх, буудай, төмс, хүнсний ногоо, тосны ургамлын үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээг бүрэн хангах, улмаар экспортын чиг баримжаатайгаар хөгжүүлэх;	2014 - 2020			Үр тариа, буурцагт таримлын төрөл сортуудын тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор гурвалжин будаа, вандуй тариалах сонирхолтой аж ахуйн нэгж, иргэд зориулсан сургалтыг Девольопмент ХХК-тай хамтран хэрэгжүүлснээр 40 гаруй аж ахуйн нэгж, иргэд оролцов. Тэдгээр аж ахуйн нэгжүүдээс гэрээ байгуулсан 22 аж ахуйн нэгжид нийтдээ 2.4 тонн үр зээлээр олгох ажлыг Девольопмент ХХК зохион байгууснаар нийтдээ 6904 га-д гурвалжин будаа тариалж ургац хураалтын дүнгээр 2807 тонн ургац хураан авч Япон улсад 600 тонн гурвалжин будаа экспортлохоор гэрээ байгуулан ажиллаж байна. Төмс 14.9 мянган га талбайгаас 190.8 мянган тн, хүнсний ногоо 8.3 мянган га талбайгаас 98.6 мянган тн хураан авч төмсний хэрэгцээг 100 хувь, ногооны хэрэгцээг 40 хувь хангасан. Хүнсний ногооны таримлын бүтцийн хувьд 2019 оны байдлаар нийт ургацын 20.3 хувь нь байцаа, 33.9 хувь нь шар лууван, 21.5 хувь нь шар манжин, 0.5 хувь нь хүрэн манжин, 9.1 хувь нь сонгино, 1 хувь нь сармис, 4.3 хувь нь хэмх, 2.5 хувь нь лооль, 7 хувийг бусад ногоо эзэлж байна. Бусад ногоо гэдэгт бага тархацтай амтат чинжүү, брокли, навчит салат, тарвас, хулуу, амтат гуа, улаан лууван, бууцай зэрэг сүүлийн 5 жилд нилээдгүй тариалж байна.	70%
29	3.1.12. Эрчимжсэн мал аж ахуйг бүх	2014 - 2020			Тэжээлийн таримлын үрийн нөөц бүрдүүлэх, тариалах талбайн	70%

	төрлийн тэжээлээр хангах, уургийн өндөр агууламжтай таримлыг нутагшуулах, сортын үрийн нөөц бүрдүүлэх;				хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор тэжээлийн вандуйн нутагшсан сортын үрийг “Элит үр” ХХК-ийн дэмжлэгтэйгээр жил бүр 20 га-д тариалж үржүүлж байгаагийн зэрэгцээ ОХУ-ын Алтайн хязгаараас 2018 онд тэжээлийн хошуу будааны 160 тонн үрийг тариалан бүхий аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтээр нийлүүлж үржүүлэн жил бүр 350-500 тонн тэжээлийн хошуу будаа, вандуйны үрийг дотоодын зах зээлд нийлүүлэх боломж бүрдүүлснээр сүүлийн 2 жилд тэжээлийн таримлын тариалалт 14.0-15.0 мянган га-гаар нэмэгдэж 2019 онд 36.0 мянган га-д хүрэв. БНБеларусь улсын Засгийн газрын хөнгөлөлтэй зээлийн хөрөнгөөр тариалангийн бүс нутагт сүүний чиглэлийн цогцолбор ферм байгуулахаар тендерийн материал боловсруулан сонгон шалгаруулалт зарлахаар бэлтгэж байна. Энэхүү төсөл хэрэгжсэнээр тус бүр 600 хүртэл үнээтэй 5 ферм тариалангийн аж ахуйн нэгж дээр байгуулагдснаар уургийн өндөр агууламжтай таримал тэжээлийн тариалалт нэмэгдэх болно.	
30	3.1.13. Өвөл, зуны хүлэмжийн болон зoorийн аж ахуйг хөгжүүлэн хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, хот, суурингийн хүн амыг жилийн турш шинэ ургацын ногоогоор тогтвортой хангах.	2014 - 2020			Ховд аймагт хүнсний ногооны 1000 тонн багтаамжтай зoorь байгуулах ажил 90 хувийн гүйцэтгэлтэй. Гэрээг 2020 оны 06 сар хүртэл сунгасан. Сүхбаатар аймагт хүнсний ногооны 500 тонн багтаамжтай зoorь байгуулах ажил дууссан. УБ хотод төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийн борлуулалтын цогцолбор төвийн ТЭЗҮ-д үерийн уснаас хамгаалах нэмэлт зураг төсөв зохиох, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх зөвлөхийн ажлууд хийж дууссан. Засгийн газрын 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар Хөдөө аж ахуйг их сургуулийн дэргэд “Хүнсний ногооны хүлэмжийн жишиг агропарк, сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах” инновацийн төсөл хэрэгжүүлэх төрийн өмч давамгайлсан гарааны компани байгуулахаар шийдвэрлэв. Төслийн хүрээнд БНХАУ-ын хөрөнгө Тяньжин хотын хөрөнгө оруулалтаар 10 га талбай бүхий өвөл, зуны хүлэмж байгуулж жилд 600-800 тонн ургац хураан авахаар төлөвлөж байна. ЖДҮ-ийг дэмжих сангаас 2019 онд 6 аймаг,	70%

					<p>нийслэлийн 9 аж ахуйн нэгжид нийт 736.4 сая төгрөгийн зээлийг өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах төсөлд олгож хүлэмжийн талбайг 7000м<sup>2</sup>-аар ургацыг 210 тонноор нэмэгдүүлэх боломж бүрдүүлэв. БНСУ-ын Гангвон мужийн 550.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Төв аймгийн Зуунмод хотод 1000 м<sup>2</sup> орчин үеийн дэвшилтэт гидропоник технологийн давхар хүлэмж байгуулав. Баянчандмань суманд Бизнес интернешнл маркет ХХК Голланд технологиор 4 улирал ашиглах боломтой 2000 мкв гидропоник технологийн автотамат удирдлагатай шилэн хүлэмжийг аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулан өргөст хэмх тариалаад байна. Герман улсын хөрөнгө оруулалтаар 1972 онд баригдсан Борнуур сумын 7200 мкв талбай бүхий шилэн хүлэмжийг “Эко урьхан” ХХК худалдан авч нийт 600 сая төгрөгийн их засвар хийж, өргөст хэмх, улаан лооль, чинжүү, тарвас зэрэг ногоог тариалсан. 1800 мкв талбай бүхий 2 хүлэмжийг өвлийн хүлэмж болгон гүзээлзгэнэ, усан үзэм тариалж байна. 2019 онд ЖДҮДС, ОУБ, хувийн хэвшлийн 3.4 тэрбум хөрөнгө оруулалтаар нийт 18800 м<sup>2</sup> буюу 1.8 га хүлэмж байгуулав.</p>	
4.1. Хүнсний аюулгүй байдал, боловсруулах үйлдвэрлэл						
31	4.1.1. Монгол Улсын хүнсний хангамжийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, төлөв байдлыг үнэлэх, хүрэх түвшинг тодорхойлох;	2014 - 2020		<p>ҮСХ-ны даргын 2015 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-д хүнсний хангамжийн шалгуур үзүүлэлтийг 1. Хүнсний хангамжийн тогтвортой байдал 2. Хүнсний хангамжийн тэнцвэрт байдал гэж тогтоосон. 2017 оны байдлаар 1 дэх шалгуурын гүйцэтгэл 49.3 хувь, 2 дахь шалгуурын гүйцэтгэл 51.1 хувьтай буюу хүнсний хангамж улсын түвшинд хангалтгүй байна. Засгийн газрын 2019 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" үндэсний хөтөлбөрт 2021 он гэхэд Хүнсний хангамжийн тогтвортой байдал шалгуурын хүрэх түвшинг 70 хувь, хүнсний хангамжийн тэнцвэрт байдал шалгуурыг 30 хувьд хүргэнэ гэж тус тус тодорхойлсон. Хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг гаргахад шаардлагатай 2019 оны</p>	40%	



					статистикийн нэгдсэн дүн мэдээлэл гараагүй байна.	
32	4.1.2. Эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр хүн амыг жигд хүртээмжтэй хангах, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, импорт орлох хүнсний үйлдвэрлэлийг дэмжих;	2014 - 2020			Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд жишиг сүүний үйлдвэр байгуулах “Витафит милк” ХХК-ийн санаачилсан төслийг бодлогоор дэмжиж, тус үйлдвэрийг байгуулахад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхэд дэмжлэг үзүүлэх хүсэлтийг БОАЖЯ-нд 2019 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 336 тоот албан бичгээр хүргүүлсэн. Хоногт 5 тн сүү боловсруулах хүчин чадалтай эдгээр үйлдвэрүүд 2019 оны 10 дугаар сард ашиглалтад бүрэн орсон. Мөн аяны хүрээнд алслагдсан орон нутгийн сүүний нөөц ашиглан импортыг орлох, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилготой “MDM” ХХК-ийн санаачлан хэрэгжүүлж байгаа “Монгол хуурай сүү” төслийг бодлогоор дэмжиж, хамтран ажиллаж байна. Төслийн хүрээнд 2019 оны 5 дугаар сард Хэнтий аймгийн Баянхутаг, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул, Галт суманд хуурай сүүний жижиг үйлдвэр ашиглалтад орсон. Өвөрхангай аймгийн Богд суманд орон нутгийн хөгжлийн сангаас 45 сая.төгрөг, аймгийн ЗДТГ-аас дэд бүтэц цахилгаан шугам сүлжээнд 10 сая.төгрөг гаргаж загвар үйлдвэр байгуулах ажлыг зохион байгуулж байна. Ирэх онд тоног төхөөрөмж суурилуулах ажлыг хийнэ. Төслийн хүрээнд нийт 7 үйлдвэр ашиглалтад оруулсан. 2019 онд 3 үйлдвэр үйл ажиллагаа явуулж 3000 кг хуурай сүү үйлдвэрлэсэн.	70%
33	4.1.3. Стратегийн хүнсний улирлын нөөцийг эрэлт, нийлүүлэлт, хэрэглээний онцлогтой уялдуулан хувийн хэвшлийн оролцоотойгоор бүрдүүлэх;	2014 - 2020			Засгийн газрын 2016 оны 212 дугаар тогтоолоор Мах, сүүний анхдугаар аяныг 2017 оноос улс орон даяар эхлүүлэхээр шийдвэрлэж, ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-45 дугаар тушаалаар аянг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байна. Засгийн газрын 2018 оны 218 дугаар тогтоолын хүрээнд арилжааны банкны эх үүсвэрээр мах бэлтгэсэн дотоодын үйлдвэрт хүүгийн хөнгөлөлт үзүүлж, нөөцөлсөн махыг хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулах арга хэмжээг зохион байгуулж, нийслэлийн 8 дүүргийн хүнсний 137 дэлгүүрээр дамжуулан үхрийн ястай мах 7200 төг/кг, хонины ястай	70%

					мах 6000 төг/кг, ямааны ястай мах 5500 төг/кг үнээр худалдаалж байгаа нь зах зээл дэх жижиглэнгийн үнээс 16-45 хувиар хямд байна. Нийслэлийн хүн амын 2019 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд 12.6 мян.тн махны шаардлагатай ба бэлтгэсэн махны хэмжээ 31,6 хувийг эзэлж байна.	
34	4.1.4. Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан мах, сүүн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх;	2014 - 2020			Мах: Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэмжээ 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 31.6 мянган тн байна. Сүү: Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 168,1 сая.литр хүрч нийт үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний эзлэх хувь 17 болсон. /2019 оны статистикийн мэдээ хэвлэгдэн гараагүй байна/	70%
35	4.1.5. Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхийг эд, бүтээгдэхүүнийг хүлээн авах, анхан шатны болон хагас боловсруулалт хийх нөхцөлийг бүрдүүлэх, хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх;	2014 - 2020			Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тус төсөл Улаанбаатар хотын баруун талд буюу Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны 15 га, хотын зүүн талд буюу Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны 14.5 га талбайд хэрэгжиж байна. Хоногт 7500 толгой бог, 1500 толгой бод төхөөрөх хүчин чадалтай үйлдвэр, 11000 тн агуулах, малын зах, худалдааны төв бүхий цогцолбор байгуулах тус төслийн дэд бүтэц баригдсан, бүтээн байгуулалтын ажил 60 хувьтай үргэлжилж байна. Хөгжлийн банкнаас тус төсөлд 2018 оны 2 дугаар сард 6.9 тэрбум, 2019 оны 6 дугаар сард 4.6 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 13.01 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатайгаар олгосон байна. Төслийг эрчимжүүлэх, санхүүгийн богино хугацааны хүндрэлийг арилгах зорилгоор НЗДТГ-аас болон тус компаниас ирүүлсэн албан хүсэлтүүдийг харгалзан бүтээн байгуулалтад шаардлагатай тоног төхөөрөмж, материалын гаалийн болон НӨАТ төлөх хугацааг хойшлуулах талаар санал боловсруулж яамдаас санал авч нэгтгэн ЗГХЭГ-г 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 01/4144 тоотой хүргүүлсэн. Тус тогтоолын төслийг Засгийн газрын 2019 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж дэмжсэн. Энэ төслийн бүтээн байгуулалтыг дуусгаж 2020 оны II улиралд ашиглалтад оруулснаар УБ хотын хүн амын мах, махан бүтээгдэхүүнээр хангах	70%

					<p>үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын сүлжээ бүрдэнэ. Төв аймгийн Мөнгөнморьт суманд ТЭСО корпорацийн харьяа Милко ХХК сүү төвлөрүүлэх цэг-1, Баянчандмань суманд “Сүү борлуулалтын төв”-1 тус тус шинээр байгуулагдаж ашиглалтад орсон. Мөн Витафит милк ХХК-ийн хөрөнгө оруулалтаар Төв аймгийн Борнуур, Батсүмбэр сумдад хоногт 1500 тн сүү хүлээн авах төв шинээр байгуулагдаж малчид, иргэдээс түүхий сүү хүлээн авч анхан шатны боловсруулалт хийж байна.</p>	
36	4.1.6. Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог төлөвшүүлж хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх;	2014 - 2020			<p>Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд хүнсний аюулгүй байдлын стандартчиллыг боловсронгуй болгох төслийн сургалтыг 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад МХЕГ, ХАБҮЛЛ, УМЭАЦТЛ, ШУТИС, ТДС, МХХ, ММХ зэрэг байгууллагын 30 гаруй хүнийг хамруулж, олон улсын эксперт оролцон үйлдвэрлэлийн зохистой дадал, НАССР нэвтрүүлэх талаар мэдээлэл, зөвлөгөө өгөв. Хүнсний боловсруулах салбарт үйлдвэрлэлийн зохистой дадал хялбаршуулан нэвтрүүлэх зааврын төслийг шинэчлэн боловсруулсан. Зааврын төсөлд цахим санал асуулгыг яамны <a href="http://www.mofa.gov.mn">www.mofa.gov.mn</a> хаягаар авч байна. Зааврын төслийн хэлэлцүүлгийг Монголын хүнсчдийн холбоотой хамтран 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналыг тусгаж, ЭМЯ, МХЕГ, СХЗГ, МХХ-нд албан бичгээр хүргүүлсэн. Улсын хэмжээнд НАССР, хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо стандарт нэвтрүүлсэн 11 үйлдвэр ажиллаж байна.</p>	40%
37	4.1.7. Хүнсний сүлжээний бүх үе шатанд хадгалалт, тээвэрлэлтийн стандарт, шаардлага хангасан ложистик сүлжээг хөгжүүлэх;	2014 - 2020			<p>ХХААХҮЯ-ны захиалгаар ТЭЗҮ-ийг гүйцэтгэсэн Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний хадгалалт борлуулалтын цогцолбор төв байгуулах төслийг "Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн" үндэсний хөтөлбөрийн зөвлөлдөх уулзалтын /2019.06.10/ үеэр гадаад улс, олон улсын байгууллагын төлөөлөгчдөд танилцуулав. Энэ төслийг хэрэгжүүлснээр Улаанбаатар хотын хүн амыг хадгалалт, тээвэрлэлтийн стандарт шаардлагад нийцсэн сүлжээгээр дамжуулан эрүүл, аюулгүй, чанартай төмс, хүнсний</p>	40%

					ногоо, жимс жимсгэнээр хангах нөхцөл боломж бүрдэнэ.	
38	4.1.8. Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлт, шилжилт, хөдөлгөөнийг хянах бүртгэл, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, мал эмнэлгийн болон ургамлын хорио цээрийн хяналтын үйл ажиллагааг сайжруулах;	2014 - 2020			Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн цахим системийг 21 аймаг, нийслэлийн 6 дүүргийн мал эмнэлгийн газар, тасаг, 332 сумын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт мал эмнэлгийн гэрчилгээний системийг шинээр суулгах, хэрэглэгчийн нууц үг сэргээх, бааз дахь мэдээ ашиглах, цахим гэрчилгээ бичих, төлөвлөгөө оруулах, дуудлага үйлчилгээ хийх үзүүлэх сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, Улсын хэмжээнд мал эмнэлгийн цахим систем нэвтрүүлж нийт 2173 малын эмч хамруулав. Мал эмнэлгийн нэгдсэн системийн хүрээнд нийт 64571 ширхэг мал эмнэлгийн цахим гэрчилгээ иргэн, аж ахуй нэгжид олгоод байна. Мөн Мал эмнэлгийн гэрчилгээний систем болон лабораторийн мэдээлэл агуулсан серверийг Үндэсний дата төв байршуулан мэдээллийн аюулгүй байдлыг хангаж байна. Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг сум, дүүргийн нутаг дэвсгэрээс гадагш худалдаалах, тээвэрлэх, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах, хээлтүүлэгт ашиглах, отор нүүдэл хийх, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд мал эмнэлгийн нэгдсэн систем ашиглаж хамтран ажиллах санамж бичгийг Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Ерөнхий малын эмч Д.Түмэндэмбэрэл Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа С.Баатаржав нар санамж байгуулав. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хөдөө орон нутгаас бэлтгэн нийлүүлж байгаа мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг сум, дүүргийн нутаг дэвсгэрээс гадагш худалдаалах, тээвэрлэх, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах үед цагдаагийн 44 пост, мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын 10 цэгээр дамжуулан хөдөлгөөнийг хяналтад оруулж, мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хамтар авч ажиллаж байна.	70%
39	4.1.9. Малын эм, бордоо, ургамал	2014 - 2020			Малын эмийн үлдэгдлийн хяналтын үндэсний хөтөлбөрийн	70%

	хамгааллын бэлдмэл, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх үлдэгдэл бодис, тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг тодорхойлох чадавх, хяналтыг сайжруулах;			хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд эмийн үлдэгдлийг тандах төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэг МЭЕГ-ын даргын 2020 оны 02 сарын 20-ны өдрийн А/42 дугаар тушаалаар томилогдон ажиллаж байна. Тус ажлын хэсэг ОУ-ын САС-ийн стандартыг орчуулан Монгол Улсын нөхцөлд тохируулан төлөвлөгөөг боловсруулж байна. “Малын эмийн үлдэгдлийн хяналт”-ын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, худалдах, эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх, эмийн сангийн үйл ажиллагааны стандартуудыг шинээр болон шинэчлэн боловсруулах ажлын хэсэг МЭЕГ-ын даргын 2020 оны 02 сарын 15-ны өдрийн А/39 дугаар тушаалаар томилогдон, “Мал эмнэлгийн эмийн сангийн бүтэц, үйл ажиллагаа”, “Малын эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагад тавих нийтлэг шаардлага”, “Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх” стандартуудыг боловсруулж байна.	
40	4.1.10. Хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хүнсний сүлжээний бүх үе шатанд хэрэглэх, дэвшилтэт технологийг нутагшуулах, үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг дэмжих;	2014 - 2020		"Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй тэмдэг", ISO/TS 22002-4 "Хүнсний аюулгүй байдлыг хангах угтвар нөхцөл-4-р хэсэг: Хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэл" Үндэсний 2 стандартын төслийг боловсруулж, СХЗГ-ын Хүнсний стандартчиллын хорооны гишүүд болон холбогдох байгууллагад хүргүүлсэн. ЕХ-ны Стандартчиллын байгууллага (CEN, the European Committee for Standardization) EN 1186-1, 3, 9:2002 нийт 3 стандартыг Монгол улсад нутагшуулах зөвшөөрөл авч, орчуулан, 1:1 орчуулгын стандартын төслийг СХЗГ-ын Сав баглаа боодлын стандартчиллын техникийн хороонд хүргүүлсэн бөгөөд шинжилгээний аргын сорил, баталгаажуулалтыг хийх ажлыг 2020 онд гүйцэтгэхээр төлөвлөсөн. Хүнсний зориулалтын хуванцар материалын аюулгүй байдлын техникийн зохицуулалт"-ын төслийн хамрах хүрээ, үндсэн бүтцийг боловсруулсан. "Сав, баглаа боодол" Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг	70%

					удирдан зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн анхны хуралдааныг зохион байгуулж, хүнс болон хөнгөний үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, 2019 онд Үндэсний Зөвлөлийн зүгээс хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг тус тус баталсан. Химийн бодисын савыг иргэдийн ахуйн хэрэглээнд ашиглахыг зогсоох аяныг 21 аймагт өрнүүлэн, үр дүнг тооцож ажиллав. "Боловсруулах үйлдвэр, цехэд түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журам"-ын төсөлд хүнсний зориулалтын сав хэрэглэн сүүг цуглуулж, хадгалж, тээвэрлэсэн бол сүүний урамшуулал олгох, мөн сүүний урамшууллын зохих хэсгийг дотоодын үйлдвэрийн, хүнсний зориулалтын, сав хэлбэрээр фермер, саальчинд олгох саналыг тус тус тусгахаар хүргүүлсэн.	
41	4.1.11. Хүнсээр дамжуулан хүний эрүүл мэндэд хохирол учруулж байгаа зөрчилд хүлээлгэх хариуцлагыг өндөржүүлэх, зөрчилтэй эвлэрсэн ойлголт, хандлагыг өөрчлөх, тавигдах шаардлагыг өндөрсгөх, нутгийн захиргааны байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааны үр дүнтэй арга хэлбэрийг хэвшүүлэх;	2014 - 2020			Эрүүгийн хуулийн /шинэчилсэн найруулга/ 20.12 дугаар зүйлийн 1-д “Эрүүл ахуйн шаардлага хангаагүй, хүний эрүүл мэндэд хохирол учруулж болох хүнсний бүтээгдэхүүн зориуд худалдсан, түгээсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан. Энэ хуулийн хэрэгжилтийг мөрдүүлж ажилласнаар хүнсээр дамжуулан хүний эрүүл мэндэд хохирол учруулж байгаа зөрчилд хүлээлгэх хариуцлагыг өндөржүүлэх, зөрчилтэй эвлэрсэн ойлголт, хандлагыг өөрчлөнө.	70%
42	4.1.12. Хүнсний аюулгүй байдал алдагдах, нийтийг хамарсан хордлого, халдварын тохиолдол, онцгой нөхцөл байдал, хямрал үүсэхээс урьдчилан сэргийлэх, үүссэн үед хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах,	2014 - 2020			БНХАУ-д шувууны томуугийн вирусын халдварын дэгдэлт бүртгэгдсэн тул шувуу, шувууны мах, үржлийн болон хүнсний өндөг, тэжээлийг эрсдэлтэй болон голомттой бүс нутгаас импортлохыг ХХААХҮ-ийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А-45 дугаар тушаалаар 2020 оны 03-р сарын 02-ныг хүртэл түр хугацаагаар зогсоож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. ХХААХҮЯ-наас НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага,	70%

	салбар дундын зохицуулалтыг идэвхжүүлэх, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импортыг хязгаарлах, хэрэглээнд нөлөөлөх, дэлхий нийтээр хэрэглээнээс хасаж байгаа өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ, импорт, худалдааг хориглох;				Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа "Хүнсний хяналтын тогтолцоог боловсронгуй болгох" төслийн төлөвлөгөөнд "Хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний дэд төлөвлөгөө"-г боловсруулах ажлыг тусгасан. Гамшгийн нөхцөлд хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний дэд төлөвлөгөөний төслийг боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮ-ийн сайдын 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн А-75 дугаар тушаалаар байгуулсан. Дэд төлөвлөгөөний төслийг нууцын зэрэглэлтэйгээр боловсруулаад байна.	
43	4.1.13. Шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, судалгааны дүнд суурилан зохицуулах үйлчилгээтэй хүнсийг үйлдвэрлэлд турших, нэвтрүүлэх;	2014 - 2020			УИХ-аас "Органик хүнсний тухай" хуулийг 2016 онд, холбогдох 4 журам, 1 аргачлал, 1 хэрэглэх бодисын жагсаалтыг 2018 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2018 оны А-09, А-180 дугаар тушаалаар батласнаар Монгол улсад органик хүнс үйлдвэрлэх эрх зүйн орчин бүрдсэн. ХХААХҮЯ органик болохыг илэрхийлсэн 6 гэрчлэх тэмдгийг оюуны өмчөөр бүртгүүлж, гэрчлэх тэмдгийн 40-0019373 дугаарт бүртгүүлсэн бөгөөд зах зээлд худалдаалагдаж буй баталгаажуулалтад хамрагдаж, бүртгэгдсэн органик хүнсийг хэрэглэгчид хялбар таних боломж бүрдсэн. Хэрэглэгчид химийн бодис, пестицид хэрэглээгүй, баталгаажсан, бүртгэлтэй органик болон шилжилтийн үеийн органик хүнсний талаарх мэдээллийг органик хүнсний бүртгэл, мэдээллийн сан <a href="http://www.organic.gov.mn">www.organic.gov.mn</a> -аас авах боломжтой болсон ба өнөөдрийн байдлаар Монгол улсад нийтдээ 12 хамтын баталгаажуулалтын байгууллага, 1 хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллага органик хүнсний баталгаажуулалтыг явуулж байна. Баталгаажсан, бүртгэлтэй 250 органик болон шилжилтийн үеийн хүнс хэрэглэгчдийн гарт очоод байна. Органик хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр хэлэлцүүлэг, мэдлэг олгох сургалтыг 70 орчим удаа зохион байгуулж, 5000 орчим хэвлэлийн материалыг олон нийтэд	100 %

					түгээв. Зах зээл дээр байгаа "органик", "байгалийн цэвэр", "байгалийн гаралтай цэвэр" гэсэн мэдэгдэл, шошго бүхий дотоодын болон импортын хүнсний бүтээгдэхүүнд улсын хэмжээнд тандалт судалгаа, олон нийтийн хяналт тавьснаар зөрлийн давтамж 2.6 дахин буурч, хэрэглэгчийн эрхийг хамгаалахад чухал дэвшил гараад байна. Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт байрлах "Монгол Фермер" дэлгүүрт Сэлэнгэ аймгийн ногоочдын тарьж ургуулсан шилжилтийн үеийн органик ногоо, зөгийн бал, хулуу чангаанзны чанамалыг зарж борлуулах "Органик дэлгүүр"-ийг нээж, хүргэлтийн үйлчилгээг санал болгож байна. Үүний үр дүнд хэрэглэгчид баталгаатай, бүртгэлтэй органик хүнсийг нэг дороос худалдан авах нөхцөл бүрдсэн	
44	4.1.14. Нийтийн хоол үйлдвэрлэлийн хоолны шим тэжээл, чанар, түүнд тавих хяналтыг сайжруулах, нийтийн хоолны үйлдвэрлэлд зэрэглэл тогтоох;	2014 - 2020			-Нийтийн хоолны газруудад зэрэглэл тогтоох, зэрэглэл олгох асуудлыг журмаар зохицуулах шаардлага гарсан тул Хүнсний тухай хуульд /ХХААХҮ-ийн сайдад эрх олгосон заалт/ нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулахаар “Хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн /2017 онд батлагдсан/-д тусгасан. Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан, хуулийн үзэл баримтлалыг 2019 оны 6-р сард батлуулж, МУ-ын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, шийдвэр, 20 дугаар тэмдэглэлээр хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон. -Хуулийн төсөлд заасны дагуу “Хоолны газруудад зэрэглэл тогтоох, зэрэглэл олгох” журмын төслийг боловсруулан холбогдох газруудаас санал авч, хэлэлцүүлсэн. Журмын төслийг ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн хурлаар 5-р сард хэлэлцүүлэхээр бэлтгэл хангаж байна. -“Хоолны газрын зэрэглэлийн шалгуур үзүүлэлт” стандартын төслийг боловсруулж, хэлэлцүүлэн, СХЗГ-т батлуулахаар 4-р сард хүргүүлнэ. Одоогоор холбогдох газруудаас санал авч байна.	70%
45	4.1.15. Нийтээр нь үйлчлэх (сургууль, цэцэрлэг, эмнэлэг,	2014 - 2020			Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.3.1-д	70%



	<p>цэргийн анги, хорих газар болон тэдгээртэй адилтгах бусад) хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, шим тэжээлийн агууламжийг дээшлүүлэх, нэгдсэн жор, технологийг боловсруулах, мөрдүүлэх, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх, дотоод хяналтыг сайжруулах;</p>			<p>"Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баглах" гэж заасны дагуу тус жагсаалтын төслийг боловсруулж, холбогдох яам, их дээд сургуулиас санал авч нэгтгэсэн. Жагсаалтын төслийг ХХААХҮ-ийн Сайдын Зөвлөлийн хурлаар 4-р сард хэлэлцүүлэн батлуулна.</p> <p>-Эмчилгээний хоолны стандартыг шинэчлэн боловсруулж, ЭМ-ийн сайдын тушаалаар 2019 онд батлуулан, эмнэлэг, сувиллын хоолны газрууд мөрдөн ажиллаж байна.</p> <p>-Давсны агууламжийг бууруулсан хоолны жор технологи, зөвлөмж цэсийг 2019 онд Гүн шим сургалтын төвтэй хамтран боловсруулж, нийслэл, орон нутгийн 300 гаруй цэцэрлэг мөрдөн ажиллаж байна. /Хоолон дахь давсны агууламж 40-60% хүртэл бууруулсан байдлаар/</p> <p>-Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн гал тогоонд зориулалтын, шаардлага хангасан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг бодлогоор дэмжин, МУ-ын ЗГ-ын 2019 оны 90 дүгээр тогтоолд "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт"-ын 14.2-д Хоол үйлдвэрлэлийн цахилгаан, хийн түлшээр ажилладаг тогоо, шарах шүүгээ, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг, эд анги" гэж заасны дагуу сургууль, цэцэрлэгийн гал тогоонд зориулалтын, чанар стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна. Тухайлбал: 2019 онд улсын хэмжээний 150 гаруй цэцэрлэг, сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийг улсын болон олон улсын байгууллагын хандиваар /5 тэрбум төгрөг/ шинэчилсэн байна.</p> <p>-ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг 2020 оны 9-р сараас мөрдөхтэй холбоотой хуулийг хэрэгжүүлэх бэлэн байдал, дотоод хяналтын тогтолцоонд үнэлгээ өгөх зорилгоор 2019 оны 5-8-р саруудад МХЕГ-аас тандалт, хяналтыг 21 аймгийн 252 сургууль, 90 дотуур байр, 385 цэцэрлэг, 7 их, дээд сургууль, 8 МСҮТ, 30 хүнсний</p>
--	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	--	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

					бүтээгдэхүүн ханган нийлүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагууд нийт 772 объектод хяналт шалгалт хийн, улсын байцаагчдын хамтарсан 626 заалт бүхий 85 албан шаардлага, 6 албан даалгавар хүргүүлэн, гүйцэтгэл үр дүнг тооцон ажиллаж хэрэгжилт 86.9 хувьтай байв.	
46	4.1.16. Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд түүхий эд бэлтгэн нийлүүлэлт, хагас боловсруулсан бүтээгдэхүүний үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн хүнсний хангамжийн ложистикийг бий болгох, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх;	2014 - 2020			<p>Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны газруудад чанар, стандартын шаардлага хангасан дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд БСШУСЯ-тай хамтран зөвлөмж хүргүүлж ажилласнаар нийслэл, орон нутагт хүнсний ханган нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн. Тухайлбал: Нийслэл хотод Багачууд хүнс, Өсвөр үе хүнс зэрэг 4 ОНӨААТҮГ-ийн 2019 оны байдлаар 50 гаруй тэрбум төгрөгийн үндэсний үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүн, түүхий эдийн нийлүүлэлт хийж, нийт худалдан авалтын 90% нь байв.</p> <p>-МУ-ын УИХ-аас 2019 онд батлагдсан Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн гол баримтлах зарчмыг орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэх гэж тодорхойлж, хуулийн 7.1.3-д “сургуулийн хоол үйлдвэрлэлийн хүнсний хангамжид орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжид хэрэглэх” гэж заасан. Ингэж бодлогоор дэмжсэн нь цаашид сургууль, цэцэрлэг дэргэдээ туслах аж ахуйг хөгжүүлэн, түүхий эдийн бүрдүүлэлт хийх нөхцөл бүрдүүлсэн.</p> <p>-Сургуулийн хоол үйлдвэрлэлд хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн сүлжээг оновчтой зохион байгуулах чиглэлээр БСШУСЯ-наас Жайка олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх төсөлд холбогдох мэдээ, мэдээллээр ханган хамтран ажилласан. Түүнчлэн "Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжсэн үндэсний хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай" БСШУС-ын Сайдын А-85 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна.</p>	40%

47	4.1.17. Мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрлэл, экспорт, импорт, хүн амын хүнсний хэрэглээний нэгдсэн мэдээллийн сан, сүлжээ бий болгох, хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлттэй холбох;	2014 - 2020		<p>Стратегийн хүнс экспортлох, импортлох зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг эхлүүлж, урилгыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулсан. 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн Үнэлгээний хорооны хурлыг хуралдуулан Саналын урилга болон ажлын даалгавартай тендерийн баримт бичгийг хураангуй жагсаалтад орсон Паблик Ютилити ХХК, Ай ти систем ХХК, Лидер вишн групп ХХК-д цахимаар хүргүүлээ. Тендерийн үнэлгээний хорооны хурлыг зохион байгуулж хураангуй жагсаалтад орсон Паблик Ютилити ХХК, Лидер вишн групп ХХК-ийн ирүүлсэн техникийн саналыг үнэлэхэд шаардлага хангасан оролцогч байгаагүй. Иймд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.1.1-д “шаардлагад нийцсэн нэг ч тендер ирүүлээгүй” гэж заасны дагуу тендерийг хүчингүй болгож дахин 2020 онд яамны төлөвлөгөөнд Стратегийн хүнс экспортлох, импортлох зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч шалгаруулах ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Стратегийн болон гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний тэнцлийг тооцоолох программ боловсруулах ажил хийгдсэн. Аль серверт байрлуулах асуудлаа шийдвэрлэсний дараа программ ашиглах нөхцөл бүрдэнэ.</p>	40%
48	4.1.18. Хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх, хяналт тавих дадал төлөвшүүлэх, өрхийн хүнсний хэрэгцээгээ хангах, сайжруулах оролцоог нэмэгдүүлэх.	2014 - 2020		<p>Хүн амын хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх мэдээлэл, сурталчилгаа болон хүнсний үйлдвэрлэгчид, судалгаа шинжилгээний ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор дараах сургалт, хэлэлцүүлгийг 2019 онд зохион байгуулж 300 гаруй хүн хамруулаад байна.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд хүнсний аюулгүй байдлын стандартчиллыг боловсронгуй болгох төслийн сургалт.</li> <li>2. Монголын хүнсчдийн холбоотой хамтран “Гурил, гурилын чанарын тухай: Чанаржуулагчийг гурилан бүтээгдэхүүнд ашиглах нь” сургалт.</li> <li>3. Монголын хүнсчдийн холбоотой хамтран “Хүнсний үйлдвэрлэлийн</li> </ol>	100 %

				<p>дотоод хяналт” сургалт. 4. “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг. 5. Стратегийн хүнс экспортлох, импортлох журмын төслийн цуврал 3 удаагийн хэлэлцүүлэг, сургалт.</p> <p>6. Төв, Хангай, Зүүн бүсийн аварга тогооч, зөөгч шалгаруулах ур чадварын уралдаан, бүсийн сургалт.</p> <p>7. Нийслэлийн мэргэжлийн хяналтын байцаагч нарт зориулсан “Жижиглэн худалдааны газрын үйлчилгээ” стандартын сургалт.</p> <p>8. Согтууруулах ундаа, түүгээр үйлчлэх норматив тогтоох захиргааны хэм хэмжээний акт боловсруулах цуврал хэлэлцүүлэг.</p> <p>9. Дэлхийн хүнсний өдрийг тохиолдуулан уламжлалт "Хүнсний аюулгүй байдал" эрдэм шинжилгээний бага хурал.</p> <p>Хүн амын хүнсний шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэх, зохистой хооллох дадлыг төлөвшүүлэх зорилгоор "Эжийн сонголт-Эрүүл хүнс", "Өглөөний цай" хөдөлгөөнийг 2019-2022 онд зохион байгуулахаар нээлтийг Дэлхийн хүнсний өдрийг тохиолдуулан 2019 оны 10 дугаар сарын 16-нд хийв. Энэ хүрээнд зөвлөлдөх уулзалтыг 2020 оны 1 дүгээр сарын 10-нд Төрийн ордонд зохион байгуулав. Зөвлөлдөх уулзалтаас хэрэглэгч, үйлдвэрлэгчдэд хандсан уриалга гаргасан.</p>	
5.1. Судалгаа ба хөгжил					
49	5.1.1. Салбарын судалгаа ба хөгжлийн тогтолцоог шинэчлэн бүрдүүлэх, шинжлэх ухаан, технологийн үр дүн, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд оролцогч талуудын уялдааг сайжруулах;	2014 - 2020		<p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан, технологи, инноваци-2016, 2018” үндэсний чуулганыг тус тус төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг оролцуулан зохион байгуулав. “Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх инновацийн хөтөлбөр”-ийг 5 зорилтын 41 үйл ажиллагааг 2016-2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А-43 дугаар тушаалаар баглуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан, технологи, инноваци-2020” үндэсний чуулганыг 10 дугаар сард зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>	70%
50	5.1.2. Нээлттэй лабораторид	2014 - 2020		“Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх	100 %

	<p>суурилсан био, нано технологийг хөгжүүлж оюуны багтаамж өндөртэй, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх;</p>			<p>ухаан, технологи, инноваци-2018” Үндэсний чуулганы хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын нийт 247 бүтээгдэхүүний мэдээлэл агуулсан “Инновацийн бүтээгдэхүүний эмхэтгэл-2016, 2018”, “Үндэсний технологи малын эм” инновацийн бүтээгдэхүүний эмхэтгэл”-ийг тус тус хэвлэн нийтэлж, олны хүртээл болгосон. Мөн салбарын эрдэмтэн судлаачид, үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчдийн үйлдвэрлэлд нэвтрүүлсэн инновацийн бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор “Инновацийн бүтээгдэхүүний үзэсгэлэн” зохион байгуулж, нийт 50 орчим байгууллага бүтээгдэхүүнээ танилцуулж, “Шилдэг бүтээгдэхүүн” номинацид 6 бүтээгдэхүүнийг шалгаруулав. ХХААХҮЯ-ны Хөгжлийн бодлогыг зохицуулах газрууд болон МЭЕГ, ХААИС, ШУТИС, бусад холбогдох эрдэм шинжилгээний байгууллагуудад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2020 оноос хэрэгжүүлж эхлэх шинжлэх ухаан, технологийн төслийн саналыг авч Шинжлэх ухаан технологийн салбар зөвлөлийн 2019 оны хуралдаанаар хэлэлцүүлэн, шийдвэрийн дагуу нийт 27 төслийн саналыг БСШУСЯ-д 2019 01/770 тоот албан бичгээр хүргүүлэв.</p> <p>ХХААХҮ-ийн Сайдын нэрэмжит Грантыг 2015, 2016 онд тус бүр 2 бүтээлд, 2017 онд 3 бүтээлд, 2018, 2019 онд тус бүр 5 бүтээлд гардуулав. Бүтээлүүдийг шинжлэх ухааны багтаамж буюу технологийн түвшин, техник эдийн засгийн үзүүлэлт, зах зээлийн эргэлтэд орох чадамжийн түвшин буюу үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, ашиглах бодит боломж, ижил төстэй технологи, бүтээгдэхүүн үйлчилгээнээс давуу тал, өрсөлдөх чадвар, нэмүү өртөг бий болгож буй түвшин зэрэг шалгуур үзүүлэлтийг хангасан байдлаар нь үнэлсэн. Салбарын яамны зүгээс оюуны багтаамж өндөртэй, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Шинжлэх ухаан, технологийн салбарын 2019 оны “Технологийн дэвшлийн шагнал”-д академич Б.Бямбаагийн “Паразиттах өвчтэй малыг эмчлэх, сэргийлэх дэвшилтэт технологи”</p>
--	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	--	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

					бүтээлийг дэмжин дэвшүүлснээр уг бүтээл нь технологийн дэвшлийн шагнал 100 сая төгрөгийн эзэн болсон.	
51	5.1.3. Шинжлэх ухаанд суурилсан ногоон үйлдвэрлэл, бизнес, хөдөө аж ахуйн аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлэх;	2014 - 2020			Байгаль орчинд ээлтэй шинэ, дэвшилтэт техник, технологи үйлдвэрлэлд нэвтрүүлж, олон улсын чанар, аюулгүйн стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, олон улсын зах зээлд үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах, зорилгоор ХБНГУ-ын нийслэл Берлин хотноо 2020.01.17-26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Ногоон долоо хоног” хүнс, хөдөө аж ахуйн олон улсын үзэсгэлэн яармагт Монгол Улсаа сурталчлан амжилттай оролцсон. Үзэсгэлэнгийн үеэр өөрсдийн онцлогийг харуулсан органик хүнсний бүтээгдэхүүний амталгаат танилцуулга, худалдаа, хоол үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүн, газар тариалангийн техник хэрэгсэл, үүлдэр омгийн мал, үндэсний түүх соёл ёс заншлаа дэлгэн харуулсан томоохон үзэсгэлэн болсон бөгөөд манай улсын ноос, ноолууран бүтээгдэхүүн, чацаргана, био бордоо зэрэг бүтээгдэхүүн европын хэрэглэгчдэд таалагдаж цаашид хамтран ажиллах боломж байгааг илэрхийлсэн байна.	100 %
52	5.1.4. Шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн технологийн инкубатор, загвар аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх;	2014 - 2020			ХХААХҮ-ийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээнд аймаг тус бүрд шинжлэх ухааны ололт үйлдвэрлэлд нэвтрүүлэх, үйлдвэрлэгч, малчид тариаланчдад мэдлэг түгээх, мэдээлэл хүргэх, сургалт, туршилт хийх боломж бүрдүүлсэн экстейншний инкубатор төв, загвар аж ахуй байгуулахаар тусгаж, хэрэгжилт хангах чиглэлээр ХХААГ-тай хамтран ажиллаж дараах арга хэмжээг хэрэгжүүлэв. Үүнд: - Орон нутгийн ХХААГ-ын экстейншны асуудал хариуцсан 12 албан хаагчийг мэргэжил дээшлүүлэх чиглэлээр БНЭУ-д сургалтад хамруулав. - Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төвийн Төв аймгийн борнуур сум дахь “Сургалт, туршилт, судалгаа, үйлдвэрлэлийн загвар аж ахуйн төв”-д (Явган хүний зам-300 м, Гүний худаг- 70 м, Сүүдрэвч-16 мкв	70%

					талбайтай, 2.5 м-ийн өндөртэй, Ариун цэврийн өрөө-Өндөр нь 2 м, урт нь 2.8 м, өргөн нь 1.5 м хэмжээтэй, Ойн зурвас байгуулахаар шар хуайс 35 ш, монос 30 ш, улиас 25 ш, голт бор 7 ш, гацуур 3 ш-ийг тарив) дэмжлэг үзүүлэв. Намираа усалгааны систем-50 морины хүчин чадалтай “Foton Lovol-504” марк усалгааны систем суурилуулж хүчин чадлыг нэмэгдүүлэв. - Технологи дамжуулах, нутагшуулах чиглэлээр ХААИС-д ХХААХҮЯ-ны дэмжлэгтэйгээр БНХАУ-ын Тяньжин Тяньжин Хүнс Групп ХХК-тэй хамтран Улаанбаатар хотын хүн амыг хүнсний ногоогоор жилийн турш хангах зориулалттай өндөр технологийн “Грийн Агро” төсөл /40 тэрбум төг/-ийг хэрэгжүүлж байна.	
53	5.1.5. Салбарын их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны материаллаг орчныг бэхжүүлэхэд олон улсын байгууллага, хандивлагч орны зээл тусламжийн хөрөнгийг нэмэгдүүлэх;	2014 - 2020		БНСУ-ын КОЙКА байгууллагын 2.1 сая ам. долларын санхүүжилтээр “Экологид ээлтэй хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүтээмжийг дээшлүүлэх нь” төслийг ХААИС, БНСУ-ын Хангионы үндэсний их сургууль хамтран хэрэгжүүлэв. Уг төслийн хүрээнд -ХАА-н гаралтай бүтээгдэхүүний хяналт, үнэлгээний лаборатори; -Хүнсний аюулгүй байдлын лаборатори; -Геномиксийн лаборатори; -Амьтны биотехнологийн лаборатори; -Сүү судлалын лабораторийг байгуулсан. Япон Улсын ЖАЙКА байгууллагын 4.0 сая ам долларын санхүүжилтээр “Монгол орны мал аж ахуй, мал эмнэлгийн салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх нь” төслийг Мал эмнэлгийн сургууль, Япон улсын Хоккайдогийн их сургууль хамтран хэрэгжүүлэв. Уг төслийн хүрээнд -Хор судлалын лаборатори; -Молекул биологийн шинжилгээний лаборатори; -Нөхөн үржихүйн биотехнологийн лаборатори; -Эм зүй, эмийн үлдэгдлийн лаборатори; Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжсэн “Дээд боловсролын шинэчлэл” төслийн хүрээнд 1. Биологийн лаборатори; 2. Мехатроникийн лаборатори; 3. Дотоод шаталтат хөдөлгүүрийн лаборатори;	100 %	

					Монгол Улсын Засгийн газрын санхүүжилтээр “Байгалийн шинжлэл, биохимийн лаборатори шинээр байгуулав. MNS ISO/IEC 17025:2018 сорилт болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавигддаг ерөнхий шаардлагыг хангуулах итгэмжлэлд хамруулах арга хэмжээг хэрэгжүүлж байна.	
54	5.1.6. Олон улсын жишигт хүрсэн түвшний судалгааны нарийвчилсан арга, технологийг эзэмшсэн хүний нөөцийг нэмэгдүүлэх, салбарын чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхийг дэмжих.	2014 - 2020			<p>Японы Олон Улсын хамтын ажиллагааны “Жайка” байгууллагын санхүүжилтээр:</p> <ul style="list-style-type: none"> <li>- ХААИС-ийн харьяа Мал эмнэлгийн хүрээлэн, Японы Обихирогийн Хөдөө аж ахуй, Мал эмнэлгийн их сургуулийн Эгэл биетэн судлалын үндэсний төвийн судлаачид 2014 – 2019 онд хамтран “Монгол оронд тохиолддог цусны шимэгч, эгэл биетнээр үүсдэг өвчний тархалтын судалгаа, оношилгооны оновчтой арга боловсруулах нь” САТРЕПС төслийг хэрэгжүүлэв.</li> <li>- ХААИС, Мал эмнэлгийн сургууль, Япон улсын Хоккайдо их сургуулиуд хамтран “Монгол орны мал аж ахуй, мал эмнэлгийн салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх нь” БНСУ-ын Засгийн газар, КОИКА байгууллага, Хөдөөгийн хөгжлийн агентлаг RDA, KOPIA-Mongolia төслийн санхүүжилтээр “Экологид ээлтэй ХАА-н бүтээгдэхүүний бүтээмжийг дээшлүүлэх нь” “Монгол орны ХАА-н салбарт өндөр технологийн судалгаа хөгжүүлэлт” Авсрали улс, ACIAR /Олон Улсын ХАА-н судалгааны Авсралийн төвийн санхүүжилтээр:</li> <li>- Монгол Улсын ХААИС, МААЭШХ, Авсралийн Күинсландын их сургуультай хамтран “Монгол улс, БНХАУ-ын бэлчээрийн менежментийг сайжруулахад урамшууллын тогтолцоог бэхжүүлэх нь” Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр: - “Ногоон алт, малын эрүүл мэнд” зэрэг дээрх Олон улсын байгууллагуудын хөнгөлөлттэй зээл, тусламжийн хүрээнд төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллав.</li> </ul> <p>Цаашид дараах Олон улсын төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламж, ХААИС-ийн Мал эмнэлгийн сургууль “Монгол</li> </ul>	100 %



					улсын мал эмнэлгийн чадавхыг сайжруулах, клиник барих” төсөл /2019-2023 он, 4.4 сая ам.дол/- Япон улсын ЖАЙКА байгууллага, ХААИС-ийн Мал эмнэлгийн сургууль “Төр, хувийн хэвшлийн малын эмч нарын практик, чадавхийг бэхжүүлэх” төсөл /2020-2024 он, 4.0 мян, ам. дол/	
6.1. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үр ашигтай зарцуулах, худалдааг хөнгөвчлөх хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:						
55	6.1.1. Улсын төсвөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт зарцуулах хөрөнгийг улсын төсвийн 3-4 хувьд хүргэх;	2014 - 2020			Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2019 оны хөрөнгө оруулалтад 44.4 тэрбум төгрөг батлагдсан. Энэ онд улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 57, гадаадын төсөл, хөтөлбөрийн 1.2 тэрбум төгрөгөөр 60, орон нутгийн төсвийн 4.1 тэрбум төгрөгөөр 297 инженерийн хийцтэй худаг, малчдын өөрсдийн санаачлагаар 219 гар худаг, нийт 6.5 тэрбум төгрөгөөр 414 инженерийн хийцтэй худаг гаргасан. Улсын төсөв, гадаадын зээл тусламжийн санхүүжилтийн хамт хөдөө аж ахуйн салбарт зарцуулах хөрөнгө төсвийн 3.7 хувьд хүрсэн.	100 %
56	6.1.2. Орон нутгийн төсвөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт зарцуулах хөрөнгийг хоёр дахин нэмэгдүүлэх;	2014 - 2020			Энэ онд улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 57, гадаадын төсөл, хөтөлбөрийн 1.2 тэрбум төгрөгөөр 60, орон нутгийн төсвийн 4.1 тэрбум төгрөгөөр 297 инженерийн хийцтэй худаг, малчдын өөрсдийн санаачлагаар 219 гар худаг, нийт 6.5 тэрбум төгрөгөөр 414 инженерийн хийцтэй худаг гаргасан. Мөн Өмнөговь аймгийн орон нутгийн төсвийн 361,5 сая төгрөгийн хөрөнгөөр 15 сумын 26 багт инженерийн хийцтэй 30 худагт нарны эрчим хүчээр ажиллах ус өргүүр суурилууллаа. Өмнөговь аймаг 2019 оныг ХАА-н үйлдвэржилтийн жил болгон зарлаж, нийт 10.3 тэрбум төгрөгийг улс, орон нутгийн төсөв, төслийн хөрөнгө оруулалтаас зарцуулсан байна. Орон нутгийн төсвөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт зарцуулах хөрөнгө 7.1 тэрбум төгрөг болсон байна.	70%
57	6.1.3. Үнэ цэнийн сүлжээний санхүүжилтийн цогц бүтцийг бий болгож, шаардлагатай шатанд хөрөнгө	2014 - 2020			Арьс ширэн түүхий эдийг үйлдвэрийн стандарт шаардлагад нийцүүлэн чанартай бэлтгэх тухай, “Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, мөшгөх тогтолцооны загвар арга хэмжээ” видео сургалтыг бэлтгэн 21 аймгийн ХХААГ, МЭГ,	70%

	оруулалтыг нэмэгдүүлэх;				<p>малчид, түүхий эд бэлтгэгчдэд хийж, TV-9 телевиз, Малчин телевизээр олон нийтэд сурталчлав.Хөдөө аж ахуйн салбарын гол нэрийн бүтээгдэхүүн мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, хөнгөн үйлдвэрийн салбарыг сэргэн хөгжүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр экспортлогч орон болох зорилгоор мал эмнэлгийн гэрчилгээний системийг Завхан аймгийн 24 сумын 116 багийн 348 малчин, сумдын Мал эмнэлгийн тасаг, нэгжийн малын эмч нар Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, сумдын удирдлага нийт 450 гаруй төлөөлөгчийг хамруулан ХХААХҮЯ, Мал эмнэлгийн ерөнхий газар, Завхан аймгийн ЗДТГ-тай хамтран аймгийн малчдын зөвлөгөөнийг 2019.05.03-04-ний өдрүүдэд Улиастай хотод зохион байгуулсан Арьс ширний үйлдвэрлэлийн салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын анхны хувийн гутлын үйлдвэр болох “Хос-Аз” ХХК нь 3 жилийн хугацаатай 2.7 тэрбум төгрөгийн “S3” олон улсын стандартын шаардлага хангасан хөдөлмөр хамгааллын 5000 хос гутлыг Оюу толгойн уурхайд нийлүүлэхээр гэрээ байгуулсан</p>	
58	6.1.4. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, үнэ цэнийн сүлжээг тэргүүлэгч аж ахуйн нэгжээр дамжуулан хөгжүүлэх;	2014 - 2020		<p>Арьс, ширний үйлдвэрийн парк байгуулж, үйлдвэрүүдийг кластераар хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх, загвар үйлдвэр байгуулахыг дэмжиж Дархан арьс ширний цогцолборын цахилгаан хангамжийн эх үүсвэрийн бүтээн байгуулалт хийгдээд байна. Мөн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг шийдвэрлэхээр мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах, экспортод гаргах Дархан арьс ширний цогцолбор байгуулах, түүнд шаардагдах хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг судлан санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий Сайдын 2019.08.06-ны өдрийн 102 дугаар захирамжаар байгуулагдав. Монгол Улсын Засгийн газар, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд</p>	70%	

				2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр байгуулсан 300 сая ам.долларын “Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн жагсаалтад “Дархан арьс ширний цогцолборын дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл” Засгийн газрын 2019.09.18-ны өдрийн 356 дугаар тогтоолоор батлагдав. Мөн Сүхбаатар аймагт хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, Хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах, Газар тариалангийн үйлдвэрлэл, Шинэ дэвшилтэт технологи бүхий гарааны бизнес, өрхийн үйлдвэрлэлийн чиглэлээр Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл, технологийн парк байгуулахаар дэд бүтцийн ажлыг эхлүүлээд байна.	
59	6.1.5. Эрсдлийг бууруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтворжуулахад даатгал, давхар даатгалын тогтолцоог цогц байдлаар нэвтрүүлэх;	2014 - 2020		Тариалангийн даатгалын тухай хуулийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл боловсруулах чиглэлээр ХБНГУ, Турк, ОХУ, Казакстан зэрэг улс, орнуудын тариалангийн даатгалын тогтолцооны талаар судалсан. "ХАА-н даатгалын бодлого, тогтолцооны шинэчлэл" сэдэвт хэлэлцүүлгийг ХХААХҮЯ, ХААИС, ХААДД ХК, Инноваци, бизнес хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулсан. Монгол улсад Тариалангийн индексжүүлсэн даатгалыг нэвтрүүлэх боломж сэдэвт ТЭЗҮ-г ХААДД ХК болон германы зөвлөх мэргэжилтнүүдтэй хамтран хийж гүйцэтгэв. Тариалангийн уламжлалт даатгал, индексжүүлсэн даатгалын төрлийг тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч нар болон таримал ургамлын үр үржүүлэх эрх бүхий 22 аж ахуйн нэгжүүдэд туршилтын журмаар даатгалд хамруулах ажлыг Давхар даатгал ХК-тай хамтран зохион байгуулж ажиллав. Мөн тариалангийн даатгалын тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгааг Тогтвортой хөдөө аж ахуй төсөлтэй хамтран гүйцэтгэлээ. Тариалангийн даатгалын тухай хуулийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан хуулийн төслийг боловсруулж 2020 оны 04 дүгээр сарын 30-ны дотор хүлээн авахаар ажиллаж байна. Тариалангийн салбарт даатгалын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Тариалангийн даатгалын хуулийн	70%

					төсөл боловсруулах ажлын хэсэгт орж холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байгаагийн зэрэгцээ таримал ургамлын үр үржүүлэх эрх бүхий 22 аж ахуйн нэгжийг туршилтын журмаар даатгалд хамруулах ажлыг Давхар даатгал ХК-тай хамтран зохион байгуулж ажиллав. ХХААХҮ-ийн Сайдын 2019 оны 119 дүгээр тушаалаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ын 3.4-т Сангаас зээл олгох тохиолдолд зээлийн эрсдэлийн болон хөрөнгийн даатгалд жил бүр заавал хамруулахаар тусгалаа. Журмын хүрээнд Сангаас шууд олгох зээлийн эрсдлийн болон барьцаа хөрөнгийн даатгалын үйлчилгээг үзүүлэх даатгалын байгууллагыг сонгох ажлыг зохион байгуулж хамтарсан даатгалын гэрээнд оролцогчид болон Монгол даатгал ХХК, Хаан даатгал ХХК-иуд шалгаран 16 төслийн 905,0 сая төгрөгийн зээлийг даатгалд хамрууллаа.	
60	6.1.6. Дэвшилтэт технологи нэвтрүүлэх, нутагшуулах, салбарын судалгаа ба хөгжлийн хөрөнгө оруулалтыг дэмжих;	2014 - 2020			Хүнсний ногоо хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 2118,5 сая, Гадаадын төсөл, хөтөлбөрөөс 3264.0 сая, аж ахуйн нэгж иргэд 2159,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тус тус хийсэн байна. Үүнээс “Монгол ногоо” төсөл – 2434.2 сая, “Хоршоолсон хэлбэрээр хүнсний ногоо эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах нь” төсөл – 829,8 сая төгрөг. Хөрөнгө оруулалтыг нийлэг хальсан хүлэмж нийлүүлэх, бага оврын хүнсний ногооны үйлдвэрлэлд зориулсан техник тоног төхөөрөмж, үр, бордоо худалдан авах, зоорь, байгуулах, ногоочдыг чадавхжуулах сургалтад зарцуулсан байна. Мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний худалдааг хөнгөвчлөх чиглэлээр мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн цахим системийг нэвтрүүлж 21 аймаг, нийслэлийн МЭГ, 6 дүүргийн тасаг, 332 сумын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт сургалт хийсэн. Энэхүү цахим систем нэвтэрснээр улсын хэмжээнд мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнийг бүрэн хянаж, чанартай эрүүл хүнсний	70%

					бүтээгдэхүүнээр хангах, чөлөөт худалдааг дэмжих ихээхэн ач холбогдолтой ажил болсон. МЭЕГ-аас 649 ААНБ-ын хүсэлтийн дагуу Монгол Улсаас мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг БНХАУ, ОХУ, БНКаЗУ, БНСУ зэрэг орнуудад экспортлох, 311 ААНБ, ТББ-ийн хүсэлтээр Казахстан, ОХУ, Киргизстан, Беларусь, БНХАУ, Польш, Япон зэрэг улсаас бүтээгдэхүүнийг импортлох “Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ” олгож, бизнесийн үйл ажиллагаа болон чөлөөт худалдаанд дэмжлэг туслалцаа үзүүлэн ажилласан.	
61	6.1.7. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт санхүүгийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх, төлөвшүүлэх;	2014 - 2020			Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А-03 дугаар тушаалын дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан арьс боловсруулах 35 багц 568.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд шилжүүлэн орон нутагт түрээсийн нөхцөлөөр олгохоор ажиллаж байна.	100 %
62	6.1.8. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалтыг бүс нутаг, ач холбогдол, чанар, бусад хүчин зүйлд суурилан эрэмбэлэн дэмжих;	2014 - 2020			ХХААХҮ-ийн салбарт 2019 онд 30 төсөл, арга хэмжээг 44.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдаж, 42.3 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн байна.	100 %
63	6.1.9. Уул уурхайн татварын орлого, нөөц ашигласны болон тусгай зөвшөөрлийн төлбөрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарын судалгаа хөгжлийн сан бүрдүүлж, зарцуулах;	2014 - 2020			Уул уурхайн татварын орлого, нөөц ашигласны болон тусгай зөвшөөрлийн төлбөрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарын судалгаа хөгжлийн сан бүрдүүлж, зарцуулахтай холбоотой эрхзүйн зохицуулалт бий болоогүй байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар 2014-2019 онуудад шинжлэх ухаан, технологийн 50 төсөл хэрэгжүүлж, эдгээр төслүүдэд Шинжлэх ухаан, технологийн сангаас 4.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.	40
64	6.1.10. Дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг түүхий эдээр хангах үйл ажиллагааг дэмжих.	2014 - 2020			Хэнтий, аймгийн Өмнөдэлгэр сумын “Ишгэн хэдмэг”, Дорноговь аймгийн Алтанширээ сумын “Олон ширээ”, Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын “Сүлэн дэнж”, Ховд, аймгийн Эрдэнэбүрэн сумын “Тунгалаг уст шураг”, Булган	100 %

					<p>аймгийн Орхон сумын “Орхон эсгий” зэрэг 70 шахам хоршоодод биржийн байнгын бус гишүүний эрх олгож, биржийн арилжаанд шууд оролцох боломжтой болсон. “Мах, хүнсний ногоо, цагаан идээ-2019” үзэсгэлэн худалдааг 2019.09.25-2019.10.01-ний өдрүүдэд Хан-Уул дүүргийн “Лавай” худалдааны төвд амжилттай зохион байгуулсан. Тус үзэсгэлэн худалдаанд 9 хоршоо, 5 аж ахуйн нэгж, олон улсын санхүүжилттэй “АДРА Монгол” байгууллагын төслийн багийн “Сэлэнгэ Органик” хоршоо /876 гишүүнтэй/, ШХА-ийн санхүүжилттэй "Монгол ногоо" төслийн багийн дундын хоршоо /1200 гишүүнтэй/, “Органик хөгжил” хамтын баталгаажуулалтын байгууллагын гишүүд, “Каритас Монгол” олон улсын санхүүжилттэй УБ хотын 6 дүүргийн тариалан эрхлэгчид оролцлоо. Үзэсгэлэн худалдааны үеэр 50 гаруй тн мах, махан бүтэгдэхүүн, 8 тонн хүнсний ногоо, жимс, жимсгэнийг хямд үнээр борлуулсан. Хөдөө аж ахуйн бирж нь Засгийн газрын 2019.05.12-ны өдрийн 191 дүгээр тогтоолын хүрээнд түүхий эдийн “Эмээлт” зах дээр хуримтлагдсан 600.0 мянган ширхэг адууны ширний стандартад нийцсэн хэсгийг дотоодын арьс ширний үйлдвэрт худалдан борлуулах, стандартын шаардлага хангаагүй адууны ширийг дэл сүүлгүйгээр Хөдөө аж ахуйн биржээр бүртгэлжүүлэн, арилжих ажлыг зохион байгуулсан. Дээрх ажлын хүрээнд “Их зам транс”, “ТМ эко хүнс”, “Улаанбаатар мах экспо” ХХК-д агуулахын итгэмжлэл олгож, биржийн байнгын гишүүн хөдөө аж ахуйн брокерын компаниудаар зуучлуулан 15 удаагийн арилжаа зохион байгуулсан.</p>	
6.2. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, гадаад худалдааг хөнгөвчлөх:						
65	6.2.1. Дотоодын үйлдвэрлэлийг төрийн дэмжлэг, тарифын болон тарифын бус зохицуулалтаар хамгаалах;	2014 - 2020			<p>Арьс шир боловсруулах үйлдвэрийг цэвэр усаар хангах, бохирыг зайлуулахад батлагдсан тарифаас өндөр хэмжээгээр төлбөр төлж байсан нь үйлдвэрлэгчдэд хүндрэл учруулж байсныг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн Үнэ тарифын алба, Монголын арьс шир үйлдвэрлэлийн холбоо, хөндлөнгийн шинжээчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг арьс</p>	70%

				шир боловсруулах үйлдвэрүүдийн бохироо зайлуулахад гарч байгаа зардлын тарифыг судалж, бодит байдал дээр лабораторийн шинжилгээгээр нотолсноор төлбөрийн хэмжээг бууруулах үндэслэлтэйг тогтоов. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2017.05.19-ний өдрийн 73 дугаар тогтоолоор тарифыг баталгаажуулсан нь үйлдвэрлэлийн өртөг буурахад бодит нөлөө үзүүлэв. Дотоодын үйлдвэрлэгчдийг төрөөс дэмжихээр нийт хөнгөн үйлдвэрийн салбарын тарифын болон тарифын бус зохицуулалтаар хамгаалах чиглэлээр салбар бүрийн онцлогт тааруулан өөрчлөлт оруулах талаар ГЕГ болон бусад холбогдох төрийн байгууллагад саналаа хүргүүлсэн. Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор дотооддоо үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай 155 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний жагсаалтыг баталлаа. Эдгээр бараа, бүтээгдэхүүнийг аливаа тендерийн үндсэн нөхцөл болгож, худалдан авах бодлогыг Засгийн газар баримтлахаар тогтсон. “Эх оронч худалдан авалт-Үндэсний үйлдвэрлэл-2019” үзэсгэлэнг 2019 оны 4 дүгээр сарын 02-03-ны өдрүүдэд Мишээл экспо” үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулсан. Үзэсгэлэнд 150 орчим үйлдвэр эрхлэгчид, 50 төрийн байгууллагууд оролцсон. Үзэсгэлэнгийн үеэр дотоодын үйлдвэрээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний биелэлтийг танилцуулах, төрийн худалдан авалтанд хэрхэн бэлтгэх, тендерт оролцогчдод тулгардаг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллав	
66	6.2.2. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний гадаад зах зээлийг тэлэх, экспортыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах;	2014 - 2020		Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хүрээнд дараахь арга хэмжээг авав. Үүнд: -Арьс ширэн түүхий эдийг үйлдвэрийн стандарт шаардлагад нийцүүлэн чанартай бэлтгэх тухай, “Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, мөшгөх тогтолцооны загвар арга хэмжээ” видео сургалтыг бэлтгэн 21 аймгийн ХХААГ, МЭГ, малчид, түүхий эд бэлтгэгчдэд хийж, TV-9 телевиз, Малчин телевизээр олон нийтэд сурталчлав.	70%

				<p>ХХААХҮЯ-ны ТНБД-ын А-40 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь ноолуурын салбарт шаардлагатай ээрэх үйлдвэрийн хөрөнгө оруулалтын тооцоо судалгааг хийж, Японы ЭЗХЯ-д, Итали, БНХАУ-ын болон бусад хөрөнгө оруулагчдад танилцуулсан -ХХААХҮ-ийн Сайдын 2019 оны А-105 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь угаасан ноолуурын экспортыг бууруулах, ноолуурын боловсруулалтын түвшинг ахиулах бодлогын хүрээнд “Ямааны ноолуурын үйлдвэрлэл худалдаанд мөрдөх” техникийн зохицуулалтын төсөл боловсруулж, холбогдох тооцоо, судалгааг хийж, ЗГХЭГ-т хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Уг техникийн зохицуулалт батлагдсанаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэнэ -Жилдээ 655 тн ноолуур самнах хүчин чадал бүхий үйлдвэрийн тоног төхөөрөмжийг 7 ААН, үйлдвэрлэгчид өөрийн хөрөнгөөр нэмж суурилуулсан. Эдгээрээс Баялаг Өлзий ХХК, Ханбогд кашемир ХХК, ЕСВ ХХК, Лидэр кашмир ХХК нь “Ноолуур” хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй хөнгөлөлттэй зээл болон ноосны урамшуулалд хамрагдсан. -Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох” журмыг шинэчлэн Засгийн газрын 2019 оны 343 дугаар тогтоолоор батлуулав.</p>	
67	6.2.3. Бүс нутгийн болон олон улсын байгууллагад гишүүнээр элсэх;	2014 - 2020		<p>2019 онд өмнөх жилүүдэд элссэн салбарын ОУ-ын болон бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон бусад хамтын ажиллагааг хөгжүүлэн ажиллаж байна.</p> <p>2016–2019 онд НҮБ, НҮБ-ын ХХААБ, Дэлхийн банк групп, ОУ-ын санхүүгийн корпорац, ХАА-г хөгжүүлэх ОУ-ын сан, Азийн хөгжлийн банк, Аж үйлдвэр, хөгжлийн байгууллага, Япон Улсын “ЖАЙКА”, БНСУ-ын “КОЙКА”, БНТУ-ын “ТИКА”, Швейцарын хөгжлийн агентлаг, Европын Холбоо, Мерси Корпс, Азийн хүнс, хөдөө аж ахуйн хамтын ажиллагааны байгууллага зэрэг олон улсын санхүүгийн болон хөгжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, үндэсний хэмжээний томоохон 12 төслийг</p>	70%



					125.4 сая ам.долларын хөрөнгөөр хэрэгжүүлсэн.	
68	6.2.4. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэг цонхны бодлогоор явуулах;	2014 - 2020			Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг дэмжих зорилгоор Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг 24/7 горимоор явуулах, ижил төрлийн бусад биржүүдтэй мэдээлэл солилцох зорилгоор Блокчейн технологид суурилсан арилжааны платформ худалдан авах тендер зарлаж байгаа ба уг систем нэвтэрснээр биржийн үйл ажиллагаа шинэ түвшинд гарах юм. Төлбөр тооцооны гүйцэтгэл буюу клирингийн үйл ажиллагааг автоматжуулах, төлбөр тооцооны гүйцэтгэлийн мэдээлэл солилцох чиглэлээр Хөгжлийн банк болон арилжааны банкуудтай хамтран ажиллаж байна. Мөн иргэд, арилжаанд оролцогчдыг мэдээллээр хангах зорилгоор <a href="http://www.order.mce.mn">www.order.mce.mn</a> захиалгын платформ нэвтрүүлсэн. Ингэснээр таваарын зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг хангах, зах зээлийн үнийн хэлбэлзлийг багасгах, малчид, хоршоодын орлогыг нэмэгдүүлэх гэх мэт олон давуу тал бий болсон. ХХААХҮЯ-наас 2016-2019 онд БНХАУ-ын ӨМӨЗО, Хайнань муж, Шанхай хот, ОХУ, Япон Улс, АНУ, ХБНГУ-уудад Хөдөө аж ахуйн олон улсын үзэсгэлэн, худалдааны арга хэмжээг түнш орнуудтай хамтран зохион байгуулж, салбарын 1100 орчим аж ахуйн нэгж, үйлдвэр эрхлэгчдийг хөнгөлөлттэй нөхцөлөөр бараа, бүтээгдэхүүнээ ОУ-ын зах зээлд сурталчлахад нь бодлогын дэмжлэг үзүүлэн ажилласан. Үүний үр дүнд нийт 8.4 тэрбум төгрөгийн борлуулалтыг тус үзэсгэлэнгүүдийн үеэр хийж, ААН-үүд худалдааны гэрээ байгуулах, шинээр экспортын зах зээлийг бий болгох, хамтарсан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах бизнес уулзалтуудыг амжилттай зохион байгуулахын сацуу Монголын уламжлалт өв, соёлыг түгээхэд тодорхой хувь нэмрийг оруулсан.	100 %
69	6.2.5. Хөдөө аж ахуйн чөлөөт бүсийг байгуулан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, алслагдсан бүс нутагт экспортын баримжаатай	2014 - 2020			Сүхбаатар аймагт хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, Хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах, Газар тариалангийн үйлдвэрлэл, Шинэ дэвшилтэт технологи бүхий гарааны бизнес, өрхийн үйлдвэрлэлийн чиглэлээр Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл, технологийн парк байгуулахаар дэд бүтцийн ажлыг эхлүүлээд байна.	40%

	үйлдвэрлэлийг дэмжих;				Улсын төсвийн 314 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар паркт ногооны хүлэмж, паркийн оффисыг тус тус барьж байгуулсан. Одоогийн байдлаар паркийн техник, эдийн засгийн үндэслэл, паркийн хөгжлийн төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг тус тус хийлгээд байна. Тус паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан 2020 оны Улсын төсөвт 400.0 сая төгрөгийг тусгаад байна.	
70	6.2.6. Мал, амьтан, таримал ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний стандартыг шинэчлэх, нутагшуулах, тэдгээрийг хөдөө аж ахуйн биржээр арилжаалах тогтолцоонд шилжүүлэх;	2014 - 2020			Ноос, ноолуурын боловсруулах үйлдвэрлэлийн технологийн хаягдал усыг эргүүлэн ашиглах судалгаа хийх аргачлал” судалгаа боловсруулсан. “Арьс ширний үйлдвэрлэлийн хаягдал усны стандарт боловсруулах, арьс ширэнд агуулагдах хорт бодисыг тодорхойлох стандарт”-ыг орчуулан, СХЗГ-г батлуулахаар хүргүүлсэн. Арьс ширэн түүхий эдийг үйлдвэрийн стандарт шаардлагад нийцүүлэн чанартай бэлтгэх тухай, “Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, мөшгөх тогтолцооны загвар арга хэмжээ” видео сургалтын материал бэлтгэн 21 аймгийн ХХААГ, МЭГ, малчид, түүхий эд бэлтгэгчдэд хийж, TV-9 телевиз, Малчин телевизээр олон нийтэд сурталчлав.	70%
71	6.2.7. Хөдөө аж ахуйн гаралтай газар зүйн заалттай, органик, брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих;	2014 - 2020			Чацаргана жимс үйлдвэрлэл, чацарганы чанамал, шүүс, хуурайшуулсан бэлдмэл, тос зэрэг брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх талаар Худалдаа аж үйлдвэрийн танхим, гадаадын төсөл хөтөлбөртэй хамтран ажилласан. Энэ төрлийн бүтээгдэхүүнийг гадаадад тогтмол экспортолдог болсон. Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж брэнд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Нийслэлээс өвлийн хүлэмж байгуулах ажлыг дэмжиж газрын асуудлыг шийдвэрлэсэн. Өвлийн хүлэмжийн цахилгааны зардлын хөнгөлөлтийг чөлөөлөх зэргээр дэмжин ажиллаж байна. Завханы улаан хальст сармис, Төв аймгийн Жаргалант сумын төмс, Орхоны хэмх, Өмнөговь аймгийн Булган сумын улаан лооль зэрэг брэнд бүтээгдэхүүн бий болсон.	70%
72	6.2.8. Гадаад оронтой байгуулсан мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн	2014 - 2020			БНХАУ-ын хорио цээрийн албаны экспертүүдтэй хамтарсан ажлын хэсэг байгуулж, тус улсад улаанбуудай, хөх тарианы гурил экспортлох хүсэлтэй манай улсын	100 %

	хэлэлцээрийн нөхцөлийг сайжруулах, шинэчлэх, шинээр байгуулах.			<p>13 аж ахуйн нэгжийн гурилын үйлдвэрт эрсдэлийн хянан магадлагааг 2019 онд зохион байгуулж Монгол Улсаас гурил экспортлох тухай протоколын төслийг БНХАУ-ын талаас 2019 оны 10 дугаар сарын 02-нд ирүүлсний дагуу МХЕГ-тай хамтран санал хүргүүлсэн. Уламжлалт аргаар боловсруулж гаргасан бүхэл үрийн гурилыг Япон Улсад экспортлох тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлж, одоогоор 1 аж ахуйн нэгж 5 тн гурил экспортлох боломжтой болоод байна.</p> <p>ДМАЭМБ-ын Ерөнхий захирал Моника Элуад манай улсын мал эмнэлгийн салбарын чадавхыг дахин үнэлүүлэх хүсэлт тавьсан.</p> <p>Франц улсаас амьд үхэр импортлох олон улсын мал эмнэлгийн гэрчилгээний нөхцөл, <u>Казакстаны мал эмнэлгийн албатай</u> хамтарч ажиллах санамж бичиг байгуулж, хоёр улсын хооронд амьд мал, амьтан, мал, амьтны махны экспорт, импортын олон улсын мал эмнэлгийн гэрчилгээний нөхцөл тохирсон.</p> <p><u>Дани улсын мал эмнэлгийн алба:</u> Монгол Улсаас санамж бичгийн төсөл, гахайн импортын олон улсын мал эмнэлгийн гэрчилгээнд тавигдах шаардлага, <u>Швейцарийн мал эмнэлгийн албатай</u> мал эмнэлгийн салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэх, Швейцарь улсаас үхрийн хөлдөөсөн үр импортлох асуудлаар Монгол Улсаас санамж бичгийн төсөл, гахайн импортын олон улсын мал эмнэлгийн гэрчилгээнд тавигдах шаардлага илгээсэн.</p> <p><u>Хятадын мал эмнэлгийн албатай</u> мал эмнэлгийн салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан ойлголцлын санамж бичгийг шинэчлэх, малын махны экспортод тавигдсан БММӨ-ний хоригийг цуцлах, Монгол Улсаас Хятад улс руу хөлдөөсөн мах экспортлох, дамжин өнгөрүүлэх асуудлаар харилцаж байна.</p> <p><u>Норвегийн мал эмнэлгийн албатай</u> мал эмнэлгийн салбарт хамтарч ажиллах асуудлаар тус улсаас ажлын хэсэг ажиллаю. <u>Узбекстан улсын мал эмнэлгийн албаныхан</u> Монгол айлчлан мал эмнэлгийн салбарт хамтарч ажиллах хэлэлцээр, мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний</p>
--	----------------------------------------------------------------	--	--	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

				олон улсын 4 мал эмнэлгийн гэрчилгээний нөхцөл тохирч гарын үсэг зурсан. Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга тэргүүтэй төлөөлөгчид Вьетнам болон Лаос улсад 2019.02.25-наас 3 дугаар сарын 01-ний өдрүүдэд ажиллав. Энэ ажлын хүрээнд Вьетнам улсын эрсдэлийн үнэлгээний баг манай улсад ойрын хугацаанд ажиллахаар тохиролцов. Монгол, Вьетнамын Засгийн газар хоорондын комиссын 16 дугаар хуралдаанаар тохиролцсоны дагуу Монгол Улсаас тус улсад гүн хөлдөөсөн хонь, ямаа, адуу болон үхрийн мах экспортлох талаар яриа хэлэлцээ хийж, мал эмнэлэг, эрүүл ахуйн гэрчилгээний загварыг хүргүүлсэн. Мөн Монгол, Лаос хоёр улсын Мал эмнэлгийн ерөнхий газар хооронд хамтран ажиллах хэлэлцээрийг байгуулж, Лаос Улсад гүн хөлдөөсөн мах, махан бүтээгдэхүүн экспортлох нөхцөл, боломж бүрдлээ.	
7.1. Хүний нөөц					
73	7.1.1. Ажиллагсдын ахуй амьдралаа сайжруулах, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдах, үйлдвэрлэлээ өргөтгөх, хорших санаачилгыг дэмжих, таатай нөхцөлийг бүрдүүлэх;	2014 - 2020		ХХААХҮ-ийн Сайдын баталсан 2019 оны “Ерөнхий нөхцөл батлах тухай” А-146 дугаар тушаалд “Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх Загвар хоршоо” –г хөнгөлөлттэй зээлээр дэмжихээр тусгасан. Журмын хүрээнд 7 хоршоонд 401,0 сая төгрөгийн санхүүжилт олгох шийдвэр гарсан. Төслийн үр дүнд 19 ажлын байр шинээр бий болж 15 ажлын байр хадгалагдана. Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн санхүүжилтээр давхардсан тоогоор 59 хоршоонд 906,3 сая төгрөгийн малын түүхий эдийн анхан шатны тордолтын цэг, сүүний цех, зөгийн аж ахуйн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. Дэлхийн байгаль хамгаалах сангийн “Ирвэстэй нутгийн ирээдүй төсөл”-ийн хүрээнд Баян-Өлгий аймгийн Бугат, Увс аймгийн Сагил сумын 2 хоршоонд сүү боловсруулах цех, Увс аймгийн Түргэн, Говь-Алтай аймгийн Дарви сумын 2 хоршоонд арьс шир боловсруулах тоног төхөөрөмж, Увс аймгийн Бөхмөрөн сумын 1 хоршоонд цөм сүргийн аж ахуйн чиглэлээр төслөөс 173,1сая төгрөг, сум, орон нутгаас 211,6 төгрөг, хоршоод өөрсдийн санхүүжилтээр 233,4 сая төгрөг, нийт 618.1 сая төгрөгийн санхүүжилт босгож, 3 төрлийн 5	100 %

					цех, аж ахуйн үйл ажиллагааг эхлүүлсэн.	
74	7.1.2. Малчин, мал зүйч, зохиомол хээлтүүлгийн техникч, малын эмчийн хөдөлмөрийг хүнд, хортой нөхцөлд хамааруулах, гэрээт ажилчид, малчдын нийгмийн хамгааллын баталгааг ажил олгогчоор хангуулах;	2014 - 2020			Малчин, мал зүйч, зохиомол хээлтүүлгийн техникчийн хөдөлмөрийг хүнд, хортой нөхцөлд хамааруулах судалгаа хийх зардлын төсвийг ХХААХҮ-ийн Сайдын 2020 оны А/21 дугээр тушаалаар батлуулан холбогдох тооцоог хийгээд байна.	40%
75	7.1.3. Малчин, мал бүхий этгээдийн өмч хөрөнгийг сайн дурын болон албан журмын даатгалд даатгуулах хүрээг нэмэгдүүлж болзошгүй эрсдлээс хамгаалах;	2014 - 2020			Малчид болзошгүй эрсдлээс хамгшаалах зорилгоор Улсын хэмжээнд 2019 онд 39.2 мянган малчин сайн дурын нийгмийн даатгалд хамрагдсан. Эрүүл мэнд нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиг үүргийнхээ хүрээнд “Өвлийг өнтэй давья” зөвөлгөөн, “Нийгмийн даатгал Малчин таны төлөө” болзолт уралдааныг зохион байгуулсан. Малын эрсдэлийн даатгалын ач холбогдолыг малчдад сурталчилж ажилласнаар энэ онд 21 аймгийн 15.5 мянган малчин өрхийн 3,258.0 сая толгой малыг эрсдрлийн даатгалд хамруулсан. Мал аж ахуйн салбарын эрсдэлийг бууруулах нэг арга зам нь малын даатгал бөгөөд энэ үйл ажиллагааг уулзалт зохион байгуулах, танилцуулах замаар Үндэсний давхар даатгал ХК-тай хамтран хэрэгжүүлж байна. 2019 онд Малын индексжүүлсэн даатгалаар 32,337 малчин өрхийг даатгалд хамруулж, 3.8 тэрбум төгрөгийн хураамжийн орлогыг төвлөрүүлсэн нь МИД-ын борлуулалт хийж эхэлснээс хойш хамгийн өндөр хураамжийн орлого төвлөрүүлсэн жил боллоо. Даатгуулсан малчин өрх нь нийт малчин өрхийн 19.05%-ийг эзэлж, 2018 онд даатгуулсан малчин өрхөөс 1381 өрхөөр буурч, даатгалын хураамжийн орлого 383.0 сая төгрөгөөр өссөн. 2018 онд малаа даатгуулсан 33719 малчин өрхөөс Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий гэсэн 9 аймгийн 31 сум, Улаанбаатар хотын Багахангай дүүрэг, нийт 3005 малчин өрхөд	70%

					323.3 мянган төгрөгийн нөхөн төлбөр олгосон.	
76	7.1.4. Малчид, тариаланчдын ая тухтай амьдрах, тогтвортой ажиллах нөхцөлийг сайжруулах, малчин эмэгтэйчүүд, залуу малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх;	2014 - 2020			Улсын хэмжээнд бүх сумын төв Mobicom, Unitel, Gmобail утасны сүлжээ бий болж, сүлжээ тархах антен суурилсан газраас ил харагдах 50-70 км радиус бүхий газрын малчид аль нэг утасны сүлжээгээр ярих боломж бүрдсэн. Малчдын залуу халааг бэлтгэх мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор мэргэжил үйлдвэрлэлийн сургалтын төвтэй хамтран 10 мэргэжлийн 300 гаруй малчин бэлтгэсэн. ОУ-ын төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран мал, малын гаралтай бүтээгдэхүүн, ашиг шимийг боловсруулах чиглэлээр 3200 гаруй малчдыг сургалтад хамруулсан. Энэ онд арьс шир боловсруулах анхан шатны цех 23, дайвар бүтээгдэхүүн боловсруулах 3 үйлдвэр шинээр байгуулагдсан. Улсын хэмжээнд малжуулах төслийг хэрэгжүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 1000 гаруй өрхөд 5.2 тэрбум олгосон байна. ШХА-ын Ногоон алт - Малын эрүүл мэнд төслийн зүгээс төсөл хэрэгжүүлж буй аймгуудын бэлчээр ашиглалтын хэсгүүдэд малын үүлдэр угсааг сайжруулах, хадлан тэжээл бэлтгэх, сүргийн эргэлт зохиох талаар сургалтуудыг тус тус зохион байгуулж нийт 7000 гаруй малчин хамруулсан.	100 %
77	7.1.5. Агрономич, механикжуулагч, инженер техникийн ажилтныг тариалангийн аж ахуйн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан бэлтгэх, сургалтын орчныг сайжруулах, сургалтын агуулгыг олон улсын жишигт нийцүүлэх, үйлдвэрлэлийн дадлагыг сургалттай хослуулахад чиглүүлэх;	2014 - 2020			“Агро трак” ХХК-тай хамтран механикжуулагч нарт зориулсан Үр тарианы комбайны ашиглалт, засвар үйлчилгээ сэдэвт сургалт зохион байгуулж 25 механикжуулагч хамруулав. 2019.06.07-ны өдөр “Инженерийн сургалтын чанар-үйлдвэрлэлийн хөгжил-хамтын ажиллагаа” Улсын зөвлөгөөн зохион байгуулав. Тус зөвлөгөөнд ажил олгогч хувийн хэвшлийн төлөөлөл, эрдэмтэн, судлаачид оролцож инженер, техникийн ажилчдын мэргэжлийн чадварыг дээшлүүлэх, сургалтын хөтөлбөрийг чанаржуулах чиглэлийг хэлэлцэж зөвлөмж гаргав. Зөвлөмжийн хүрээнд хөдөө аж ахуйн инженерийн чиглэлийн сургалтын орчныг сайжруулах, сургалтын агуулгыг олон улсын жишигт нийцүүлэх, үйлдвэрлэлийн дадлагыг сургалттай хослуулахад чиглүүлэх ажлын хөтөлбөр боловсруулж "Атар-4" тариалангийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга	70%

					хэмжээний төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.	
78	7.1.6. Салбарын мэргэжилтэн, инженер техникийн болон бусад мэргэжилтэй ажилтны төгсөлтийн дараах болон мэргэжил дээшлүүлэх сургалтыг явуулах зайн сургалтын тогтолцоог хөгжүүлэх, мэргэжлийн ур чадварыг тодорхойлох, мэргэшлийн зэрэг олгох;	2014 - 2020			Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.53.3 заалтын дагуу "Мэргэжилтэй ажилтан" хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮЯ-ны ТНБД-ын А-430 тушаалаар баталж, суурь судалгаа, ажлын төлөвлөгөө боловсруулсан. - Ноос ноолуур, арьс шир, оёдол, ой модны үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөн уулзалт, хэлэлцүүлгээс "Мэргэжилтэй ажилтан" хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага, зөвлөмж гаргаж, хөтөлбөрийн төслийг танилцуулсан. Мөн "Үйлдвэржилт 21:100", "Ноолуур" хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн суурь судалгааг үндэслэн хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдлын судалгаа хийв. -Хөнгөн үйлдвэрийн 85 жилийн хүрээнд 9 салбараас хүний нөөцийн бэлтгэл, тулгамдаж буй асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж, салбар бүрээс судалгаа авч байна - Мэргэжлийн ур чадвар тогтоох, мэргэшлийн зэрэг олгох журмыг өөрчлөх, шинэчлэн боловсруулахаар БСШУСЯ, ХНХЯ, ШУ-ны сургуулиудаас санал авах төслийг боловсруулаад байна. ХНХЯ-ны харьяа Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвтэй "Хамтран ажиллах гэрээ" байгуулж, "Хүн амын ахуйн үйлчилгээ – 2020" нийслэлийн дэд хөтөлбөрийн холбогдох 7 үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлж байна. Ахуйн үйлчилгээний салбарын ажилтнуудын ур чадварын үнэлгээний систем боловсруулах ажлын хүрээнд ахуйн үйлчилгээний 8 ангиллын нийт 10 төрийн бус байгууллагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэх талаар уулзалт зохион байгууллаа.	70%
79	7.1.7. Малчид, тариаланчдад үйлдвэрлэл, технологи, бизнес, байгаль, цаг уурын өөрчлөлтийн талаар зохистой мэдлэг олгох сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу мэдээллийн болон бусад хэрэгслийг ашиглан	2014 - 2020			ОУ-ын төсөл, хөтөлбөрийн хүрээнд 18 аймгийн давхардсан тоогоор 60 гаруй мянган малчинд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх, технологи, бизнес, байгаль, цаг уурын өөрчлөлтийн талаар зохистой мэдлэг олгох танхимын сургалт зохион байгуулсан. Мөн видео сургалтын 2 материал бэлтгэн олон нийтийн телевизээр нэвтрүүлсэн. Тариаланч, ногоочид, сургагч багш, салбарын ажиллагсдын чадавхыг нэмэгдүүлэх, бэхжүүлэх ажлын хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтөд	100 %

	тасралтгүй явуулах;				дасан зохицсон тогтвортой газар тариаланг дэмжих зорилгоор 7 удаагийн сургалт, зөвлөгөөн, онол үйлдвэрлэлийн бага хурал зохион байгуулж 350 гаруй хүн хамруулав.	
80	7.1.8. Нүүдлийн соёл, иргэншил, уламжлалд суурилсан аялал, жуулчлалыг малчдын ахуй амьдралд түшиглэн хөгжүүлэх.	2014 - 2020			“Сайханы сарлаг”, “Ингэний айрагны баяр”, “Говь фестиваль”, “Адуучин тэмцэн”, “Мөсний баяр”, “Цааны баяр” зэрэг арга хэмжээг орон нутагт жил бүр уламжлал болгон малчдын ахуй амьдралд түшиглэн хөгжүүлэх зорилгоор зохион байгуулж аялал жуулчлалыг татах, мал аж ахуйн болон газар тариалан, гар урлалын бүтээгдэхүүнээ зарж борлуулах, малчдын орлогыг нэмэгдүүлэх үр дүнгэй ажил болсон.	70%